

МОНГОЛ УЛС
ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ



**МОНГОЛ УЛСАД СОНГУУЛЬ ЗОХИОН ЯВУУЛАХТАЙ
ХОЛБООТОЙ ҮЙЛДЭГДДЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

(ГАРЫН АВЛАГА)

Улаанбаатар хот
2016 он

Цагдаагийн алба хаагчдын албан хэрэгцээнд зориулав.

**МОНГОЛ УЛСАД СОНГУУЛЬ ЗОХИОН ЯВУУЛАХТАЙ
ХОЛБООТОЙ ГАРДАГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙГ ШАЛГАХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

ГАРЫН АВЛАГА

©Хууль сахиулахын их сургууль
Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэн, 2016 он

Зохиогч: М.Эрдэнэбаяр, Д.Мягмарцэрэн, Г.Бямбадорж
Я.Цэлмэн, Д.Сумъяацэрэн, Э.Золбоо

ГАРЧИГ

Өмнөх үг	4
Нэг. Сонгуулийн хуулийн тухай ерөнхий ойлголт, нийтлэг гардаг хэрэг, зөрчил	5
Хоёр. Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан зарим нэр томъёоны тухай	8
Гурав. Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчих үйлдэл, эс үйлдэл	10
Дөрөв. Сонгууль зохион байгуулан явуулахад цагдаагийн байгууллагын оролцоо	11
Тав. Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан зөрчил, түүнийг шалгахад анхаарах асуудал	17
Зургаа. Эрүүгийн хуульд заасан Иргэдийн Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад анхаарах зарим асуудал	24
Долоо. Сонгуулийн автоматжуулсан систем	33
7.1. Сонгуулийн автоматжуулсан систем түүний аюулгүй байдлыг хангах	33
7.2. Сонгуулийн автоматжуулсан системийн бүтцийн тухай ойлголт	33
7.3. Сонгуулийн автоматжуулсан системд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг ашиглах	36
Найм. Цахим мэдээлийн хүрээнд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн арга үндэс	37
Эх сурвалжийн жагсаалт	41
Эрүүгийн хууль, Сонгуулийн тухай хуулийн зөрчлийн ялгаа ба ижил төстэй тал	42

Өмнөх үг

Монгол Улсын Үндсэн хуульд иргэдийн баталгаатай эдлэх багц эрх бол иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө юм. Иргэд дээрх эрх эрх чөлөөгөө эдэлснээр нийгмийг удирдан зохион байгуулах үйл хэрэгт идвэхтэй оролцож, түүгээрээ хувь хүн зөвхөн өөрийн эрх ашгаа төдийгүй нийгмийн удирдлага зохион байгуулалтад шууд болон шууд бусаар нөлөөлдөг.

Иргэдээс төрийг удирдах хэрэгт оролцох байнга давтагддаг, хамгийн өргөн эрх бол сонгууль юм. Сонгууль нь дарамт шахалтгүй, хүн бүр чөлөөтэй оролцох, хуурч мэхэлсэн элдэв арганд автаагүй хэрэгжих бүх нөхцөл бүрдсэн байх ёстой. Энэ баталгааг хангах нэгээхэн хэсэг нь сонгууль зохион байгуулахтай холбоотой гардаг хэрэг, зөрчлийг үнэн зөв бодиттойгоор, шуурхай шалгаж, гэм буруутайд нь хариуцлага ногдуулах явдал юм.

Иймд, сонгуулийн үед гардаг гэмт хэрэг, зөрчлийг шалгах гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх болон сонгуулийн хууль тогтоомжтой холбоотой зүйл заалтыг нэг мөр ойлгох, үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлэх талаар цагдаагийн байгууллагын алба хаагчдад давын өмнө хэрэг болохуйц зөвлөгөө, гарын авлагыг өмнөх сонгуулийн үед гарч байсан хэрэг, зөрчлийн баримтад тулгуурлан боловсруулан Та бүхэнд хүргэж байна.

Зохиогчид

НЭГ. СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ, НИЙТЛЭГ ГАРДАГ ХЭРЭГ, ЗӨРЧИЛ

Цагдаагийн байгууллагын ажилтнуудаас сонгуулийн тухай хуульд заасан зөрчил, түүнийг танин мэдэх, эрүүгийн хуульд заасан энэ төрлийн гэмт хэргээс ялган зүйчлэх, хэрэг маргааныг шалгахад сонгуулийн тухай хуулийн ерөнхий ойлголт, нэр томъёо, зөрчлийн талаар мэддэг байх нь хэрэг зөрчлийг бодиттой, үнэн зөв, хууль зүйн дагуу шалгаж, шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой.

Ингээд сонгуулийн хууль, тогтолцоо болон шинэ хуульд орсон зарим өөрчлөлтийн талаар товч ойлголтыг өгье.

Монгол Улсад зохион байгуулан явагддаг сонгууль тус бүр өөрийн хуультай байсан нь нэр дэвшигч, иргэд сонгуулийн тогтолцоог ойлгоход бэрхшээлтэй, эдгээр хуульд тусгагдсан заалтууд өөр хоорондоо зөрчилтэй зохицуулалт нь төвөгтэй байдлыг бий болгож байв. Нөгөөтэйгүүр 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дараа улс төрийн намууд, иргэд, сонгогчид, судлаачдын зүгээс УИХ-ын сонгуулийн тухай хуулийг Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн шинэчлэх, боловсронгуй болгох талаар шаардах болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2012)¹, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2011)², Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль³, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай (2012)⁴ хуулийг нэгтгэн тэдгээрийг бүхэлд нь “Сонгуулийн хууль” гэж нэрлэж, сонгуулийн зохион байгуулалт, бэлтгэлийн уялдааг хангах, зөрчлийг арилгах зэргээр боловсронгуй болгожээ.

Өнөөдөр манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сонгуулийн тухай хууль тогтоомж нь 2006 онд батлагдсан “Сонгуулийн төв байгууллагын тухай” хууль, 2011 онд батлагдсан “Сонгуулийн автоматжуулсан системийн тухай” хууль, 2015 онд батлагдсан “Сонгуулийн тухай” (цаашид Сонгуулийн хууль гэх) хууль байна.

Сонгуулийн хуулийн зорилт нь Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал (цаашид орон нутгийн хурал)-ын сонгууль, үндсэн зарчим, журмыг тодорхойлж, эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршиж байна.

Сонгуулийн тухай хууль нь хоёр хэсэгээс⁵ бүрдэх бөгөөд хэсэг тус бүр бүлэг, дэд бүлэгтэй, нийт 19 бүлэг, 166 зүйлтэй байна.

Тус хуулийн нэгдүгээр хэсэгт:

1. Ерөнхий үндэслэл: Сонгуулийн хуулийн үндсэн зарчим, хэлбэр, төрөл, сонгуулийн шат, хугацаа.

2. Сонгуулийн эрх: Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх, сонгуульд нэр дэвшүүлэх эрх, давхар нэр дэвшихийг хориглох асуудал.

3. Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс: Ээлжитболон ээлжит бус, нөхөн, дахин сонгууль товлон зарлах, сонгуулийн санал авах өдөр,

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай. Монгол Улсын хууль 2015.12.25 //Төрийн мэдээлэл сэтгүүл. 2016.01.22. №04 /913/ 201 дэх тал.

² Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай. Монгол Улсын хууль 2015.12.25 //Төрийн мэдээлэл сэтгүүл. 2016.01.22. №04 /913/ 200 дахь тал

³ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай. Монгол Улсын хууль 2015.12.25 //Төрийн мэдээлэл сэтгүүл. 2016.01.22. №04 /913/ 201 дэх тал

⁴ Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль хүчин болсон тухай. Монгол Улсын хууль 2015.12.25 //Төрийн мэдээлэл сэтгүүл. 2016.01.22. №04 /913/ 201 дэх тал

⁵ Нэгдүгээр хэсэгт: Сонгуулийн үйл ажиллагааны ерөнхий зохицуулалт.

Хоёрдугаар хэсэгт: УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгууль, нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, дүн гаргах зэрэг сонгууль тус бүрийн онцлог зохицуулалтууд багтана.

4.Сонгуулийн нутаг дэвсгэрийн зохион байгуулалт: Сонгуулийн нутаг дэвсгэр, сонгуулийн тойрог, сонгуулийн хэсэг.

5.Сонгуулийн байгууллага: Сонгуулийн байгууллага, удирдлага, зохион байгуулалт, гадаад улсад байгаа иргэдийн санал авах сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны дотоод журам, сонгуулийн байгууллагын ажилтан албан тушаалтан тэдгээрийн эдийн засаг, хууль зүйн баталгаа, сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, санал авах, тоолох ажлыг зохион байгуулах нэгж.

6.Сонгууль зохион байгуулах эдийн засгийн үндэс: сонгууль зохион байгуулах зардал, сонгууль зохион байгуулах үйл ажиллагаанд туслах.

7.Сонгуулийн сурталчилгааны эдийн засгийн үндэс: сонгуулийн зардал, сонгуулийн хандив, сонгуулийн зардалд зарцуулах хөрөнгө, сонгуулийн зардлын хяналт, тайлан.

8.Сонгогчдын нэрийн жагсаалт: Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам, сонгогч шилжих, иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох.

9.Сонгуулийн сурталчилгаа: Сонгуулийн мөрийн хөтөлбөр, сонгуулийн сурталчилгаа, зурагт самбар ашиглах, сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах, сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах, сонгуулийн сурталчилгаанд интернет орчин ашиглах.

10.Саналын хуудас: Саналын хуудас, хэвлүүлэх, хамгаалах, хадгалах.

11.Санал авах ажиллагаа: Санал авах газар, хугацаа, санал авах үйл ажиллагаа.

12.Санал хураалтын дүн гаргах, нэгтгэх ажиллагаа: Санал тоолох, гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох, санал хураалтын дүн, бусад бичиг баримт хүргүүлэх

13.Санал хураалт дахин явагдах: Хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох, хэсэгт дахин санал хураалт явуулах, Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь санал хураалт явуулах, нэмэлт санал хураалт явуулах.

14.Ажиглагч: Сонгуулийг ажиглах, ажиглагчийн эрх, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглах ажиглагчийн эрх.

15.Маргаан шийдвэрлэх: Өргөдөл, нэхэмжлэл шийдвэрлэх ажиллагаагомдол мэдээлэл гаргах, зөрчил шалгах, хянан шийдвэрлэх, шийтгэвэр, захирамжид гомдол гаргах.

Хоёрдугаар хэсэгт:

16.Улсын их хурлын сонгууль: нам эвсэл сонгуульд оролцох, эвслийн гэрээ, бүртгэх, нэр дэвшүүлэх

17.Ерөнхийлөгчийн сонгууль

18.Орон нутгийн сонгууль

19.Хариуцлага хүлээлгэх гэсэн бүлгүүдээс бүрдэнэ.

Сонгуулийн хуулийн нэгдүгээр хэсгийн арван таван бүлэгт буй сонгуулийн хэрэг, зөрчил маргааныг шалган шийдвэрлэх асуудал цагдаагийн байгууллагатай шууд хамааралтай болно.

Сонгуулийн хуульд орсон гол гол өөрчлөлтөөс товч дурьдвал: Сонгуулийн тогтолцоо нь УИХ сонгууль тойргоос болон жагсаалтаар, Орон нутгийн сонгууль тойргоос сонгогдоно. Гүйцэтгэх ажлын чиг үүргийн хуваарилалт, сонгогчийн нэрийн жагсаалт, хамгаалалт, зардал түүний хэмжээ, хяналт, сонгуулийн ажилтны мэдээллийн сан, байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллага, сурталчилгааны хугацаа¹⁷хоног, бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбарыг ашиглахгүй, зурагт самбарыг зөвхөн нийтийн эзэмшлийн гудамж, талбайд түр хугацаагаар үнэ төлбөргүй байрлуулна, сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар зөвхөн сонгуулийн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриаг

сурталчилна, сонгуулийн үеийн цагдаагийн байгууллагын хамгаалалт, зардал, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, түүний хэмжээ, сонгуулийн маргаан, зөрчил, шалгаж шийдвэрлэх байгууллагууд зэрэг томоохон өөрчлөлтүүд оржээ.

Ээлжит сонгууль явагдах үед намуудын үйл ажиллагаа болон иргэдийн улстөрийн идэвх сэргэж, сонгуулийн бэлтгэл ажлыг хангах, сонгуульд оролцох өрсөлдөөн нэмэгдэж ирдэг. Түүнтэй холбоотойгоор сонгуулийн маргаан, хэрэг зөрчил гарах нь ихэсдэг.

Сонгуулийн хэрэг, зөрчил маргааныг шалгаж, шийдвэрлэхэд баримтлах гол зарчим бол зөрчил маргаан нь сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн түүнтэй холбоотой эсэхэд анхаарлаа хандуулах ёстой.

Иргэд хоорондын хувийн болон байгууллагын шинжтэй маргаан зөрчлийг сонгуулийн үйл ажиллагаатай хамаатуулах, түүнийг хэвлэл мэдээллээр дэвэргэх оролдлого ихээр гардаг нь өмнөх сонгуулийн үед гарч байсан хэрэг зөрчлөөстодорхой харагддаг.

Улсын Их Хурлын болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг анх удаа 2012 оны 6 дугаар сарын 28-нд хамтад ньяймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль 2012 оны 11 дүгээр сарын 21-нд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль 2013 оны 6 дугаар сарын 26-нд тус тус явагдсан юм.

Дээрхи сонгуулийн үеэр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэрэг, зөрчил нь санал тоолох машин худлаа тоолж байна, согтуу хүн намын болон ухуулах байранд агсам тавиад байна, мөнгө, эд зүйлс тараагаад байна эсвэл мөнгө өгнө гэж амлаж байна, согтуу хүмүүс сонгуулийн байранд маргалдаад байна, аль нэг намд санал өгүүлэх гэж хүмүүсийг ятгаад байна, сонгогчдыг угтан авч нөлөөлж байна, сонгогчдын нэрсийн жагсаалтад хүн нэмж бүртгүүлсэн байна, сурталчилгаандаа хүн гүтгэсэн байна, нэр хүндийг унагах зорилгоор нэвтрүүлэг бэлтгэсэн байна, намын туг хатгасан улсын дугааргүй автомашин явж байна, сурталчилгааны самбар алга болсон, сурталчилгаа, ухуулгын байранд хүмүүс дайран орж ирлээ, тог салгаад зугтлаа, саналын хуудас тээвэрлэсэн машиныг явуулахгүй байна гэх мэт агуулгатай дуудлага мэдээллийг өгч шалгуулсан байна.

Дээрх хэрэг, зөрчил маргааныг системчлэн авч үзвэл сонгуульд нэр дэвшүүлэх, сонгогчийн нэрийн жагсаалт, сонгуулийн сурталчилгаа, ухуулах болон санал авах байр, хэвлэл мэдээлэл, сонгуулийн автоматжуулсан систем, сонгуулийн санал авах ажиллагаа, саналын хуудсыг хамгаалах, хүргүүлэх зэрэг үйл ажиллагаатай холбоотой болон бусад гэж ангилан үзэж болно.

ХОЁР.СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТУХАЙ

Сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан зарим нэр томьёог цагдаагийн алба хаагч нар зайлшгүй мэдэж байх нь хэрэг, зөрчлийг шалгахадчухалач холбогдолтой байдаг.

Сонгуулийн тухай хуульд заасан

“сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн болох нь тогтоогдсон” гэж сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөнийг шүүхээс тогтоосон хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг хуульд заасан бөгөөд мөн хуулийн 15 дугаар бүлгийн 117 дугаар зүйлд “энэ хуульд заасан захиргааны зөрчлийг цагдаагийн байгууллага шалгана” гэсэн заалтуудаас сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг цагдаагийн байгууллага шалгаж, шүүхэд шилжүүлж, шийдвэрлүүлнэ гэж ойлгох нь зүйтэй.

“гарын үсэг хуурамчаар үйлдэх” гэж бүх төрлийн арга хэрэглэн /өөрөө, эсхүл өөр этгээдээр үйлдүүлэх, техник хэрэгсэл ашиглах гэх мэт/ бусдын гарын үсгийг дуурайлгаж буюу хуулбарлаж, эсхүл зохиож зурах, сонгуулийн эрхгүй хүмүүсээр гарын үсэг зуруулахыг;

“хуурч мэхлэх” гэж үг болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгохыг;

“эд мөнгөөр татах” гэж мөнгө, эд хөрөнгө өгөх, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэргээр бусдын хүсэл зоригийн илэрхийлэлд нөлөөлөхийг;

“сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах” гэж мөнгө, эд хөрөнгө өгөх, амлах, дамжуулах, зуучлах, аливаа ажил, үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэрэг бүх төрлийн арга, хэлбэрээр сонгогчийн санал өгөх эрхийг өөрийн сонирхолд нийцүүлж, тодорхой нам, эвсэл, нэр дэвшигчид санал өгүүлэх зорилгоор явуулж байгаа ажиллагааг;

“итгэмжилсэн хүн” гэж сонгогч өөрөө тухайлан сонгож, санал авах байранд дагуулж ирсэн, санал өгөхөд нь унших, бичих хэлбэрээр туслалцаа үзүүлэх чадвартай, насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг;

“сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн” гэж сонгогч саналаа чөлөөтэй өгөх эрхэд хөндлөнгөөс хууль бус аливаа хэлбэрээр нөлөөлсний үр дүнд түүний саналыг хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл, түүнчлэн санал хураалтын эцсийн дүнг бодит байдалд нийцсэн дүнг гэж тус тус үзэх боломжгүй болохыг ойлгоно.

Сонгуулийн автоматжуулсан систем түүнтэй холбоотой зарим нэр томьёог дараах байдлаар ойлгоно.

“улсын бүртгэлд бүртгэсэн” гэж улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын иргэний бүртгэлийн мэдээллийн улсын санд биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийн бүртгэлд бүртгэсэн, иргэний бүртгэлийн дугаар олгосон байхыг;

“санал тоолох төхөөрөмж” гэж Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлаас зөвшөөрсөн санал авах, тоолох, үр дүнг тооцоолон гаргах, дамжуулах зориулалт бүхий техник хэрэгслийг;

“сонгуулийн автоматжуулсан систем” гэж сонгуульд бэлтгэж, түүнийг хуулийн дагуу зохион байгуулахад ашиглах зориулалттай мэдээллийн санг бүрдүүлж, сонгогчийн хувийн мэдээлэлтэй тулган нягтлах, сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагааг автоматжуулах үүрэг бүхий цахим мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамж, тэдгээрийг ажиллуулах хүний нөөц, санхүүгийн эх үүсвэрийн харилцан уялдаа бүхий цогцыг;

“сонгогчийн хувийн мэдээлэл” гэж тухайн иргэнийг гэрчлэх талаар хуульд заасан албан ёсны баримт бичигт туссан мэдээлэл, гэрэл зураг, биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг;

“автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл” гэж мэдээллийг оруулах, боловсруулах, нэгтгэх, хадгалах, хайх болон дамжуулах зориулалттай харилцан уялдаатай техник хэрэгсэл, програм хангамжийн нэгдлийг;

“мэдээллийн ажиллагаа” гэж сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан мэдээлэл оруулах, боловсруулах, нэгтгэх, хадгалах, хайх болон дамжуулах үйл явцыг;

“мэдээллийн технологийн даамал” гэж сонгуулийн зохих шатны хорооны автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг ашиглаж ажиллуулах, түүний хэвийн ажиллагааг хариуцан хангах чиг үүрэг бүхий мэргэжилтнийг;

“цахим түлхүүр” гэж автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, түүний аль нэг хэсгийг ашиглах, мэдээлэлд нэвтрэх, мэдээллийн санд байгаа тоон дүн, баримт бичигтэй харьцах боломжийг цахим түлхүүр эзэмшигчид олгох зорилгоор мэдээллийг нууцлан дүрс, тоон хэлбэрт оруулан үйлдсэн түлхүүрийг;

“цахим гарын үсэг” гэж сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан цахим хэлбэрээр үйлдсэн баримт бичгийн бүрдүүлбэр дэх цахим түлхүүр бүхий гарын үсгийг тус тус ойлгоно.

Цахим гарын үсгийн тухай хуульд зааснаар “цахим гарын үсэг” гэж цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэг, тоо, тэмдэг, дүрсийг агуулсан цахим өгөгдлийг;

“тоон гарын үсэг” гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрлийг, “криптограф” гэж мэдээллийг нуух аргачлалыг судалдаг математикийн салбар шинжлэх ухааныг;

“цахим баримт бичиг” гэж мэдээллийн технологийн техник хэрэгсэл, програмхангамж ашиглан үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах боломжтой цахим өгөгдлийг;

“тоон гарын үсгийн хувийн түлхүүр” гэж тоон гарын үсгийг үүсгэх, өгөгдлийг тайлах зориулалттай тэмдэгтийн давтагдашгүй дарааллыг;

“тоон гарын үсгийн нийтийн түлхүүр /цаашид “нийтийн түлхүүр” гэх/” гэж тухайн тоон гарын үсгийн хувийн түлхүүртэй математик хамааралтай, өгөгдлийг нууцлах, тоон гарын үсгийг шалгах зориулалттай тэмдэгтийн дарааллыг;

“тоон гарын үсэг эзэмшигч” гэж тоон гарын үсгийн гэрчилгээнд заасан тоон гарын үсгийн нийтийн түлхүүр эзэмшигч иргэн, хуулийн этгээдийг;

“тоон гарын үсгийн хэрэгсэл” гэж тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан цахим баримт бичгийн тоон гарын үсгийг үүсгэх, эсхүл тоон гарын үсгийн нийтийн түлхүүр ашиглан цахим баримт бичгийн бүрдэл хэсэг болох тоон гарын үсгийг шалгах, эсхүл тоон гарын үсгийн нийтийн болон хувийн түлхүүрийг үүсгэх боломж олгож байгаа техник хэрэгсэл, програм хангамжийг гэж хуульд тайлбарлажээ.

ГУРАВ. СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИХ ҮЙЛДЭЛ, ЭС ҮЙЛДЭЛ

Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил, гэмт хэрэг, иргэний хэрэг маргаан, захиргааны хэрэг маргаан гэж 4 ангилна.

Сонгуулийн тухай хуульд заасан зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх нь тухайн асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шалгахад саад болохгүй болно.

Сонгуулийн тухай хуулийн зөрчилд ногдуулах хариуцлага нь:

а) Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлсэн байдлаар торгох.

б) Төрийн албан хаагчид төрийн албанд тодорхой хугацаатайгаар эргэж орох эрхгүйгээр халах.

в) Төрийн албанаас халах./65.10-д энэ хуулийн 65.7, 65.8-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанаас хална./

г) Баривчлах. /92.16-д энэ хуулийн 92.2-д зөрчсөн иргэн, холбогдох этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна./

д) Сануулах./82.19-д Радио телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх энэ хуульд заасан журам зөрчсөн радио, телевизэд нэг удаа сануулна./

е) Үйл ажиллагааг нь зогсоох./82.19-д заасан зөрчлийг дахин давтал санал авах хүртэл үйл ажиллагааг нь тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зогсооно./

ё) Түдгэлзүүлэх. /82.21-д энэ хуулийн 82.5, 82.12-д заасныг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг харилцаа холбооны хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчил гаргасан өдрөөс эхлэн 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ./

ж) Цахим хуудасны хандалтыг хязгаарлах. /83.7-д энэ хуулийн 83.4-т заасныг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, аливаа этгээдийг олж тогтоох боломжгүй бол Харилцаа холбооны зохицуулах хороо тухайн цахим хуудасны Монгол улсаас хандах хандалтыг сонгуулийн хугацаа дуустал хязгаарлана./

з) Улсын орлогод авах. /52.4-д энэ хуулийн 52.2, 52.3-д заасныг зөрчиж... хандив хүлээн авсан бол нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасаж, авсан хандивийг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ./

Сонгуулийн зөрчилд хариуцлага оногдуулах субъект нь:

- Иргэн, /сонгогч/;
- Нэр дэвшигч;
- Хуулийн этгээд, нам, эвсэл;
- Төрийн албан хаагч, сонгуулийн хорооны дарга, нарийн бичиг, сонгуулийн байгууллагын ажилтан;
- Нам, эвслийн удирдлага, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагч, ажиглагч, нэр дэвшигч, сонгуулийн штабын ажилтан;
- Банкны захирал. /59.3-т заасныг зөрчсөн банкны захирлыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно/;
- Хэвлэл мэдээллийн ажилтан. /70.15.3-д хэвлэл мэдээллийн ажилтанд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 6-8 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно/;
- Засаг дарга. /39.6.Энэ хуулийн 39.2-т заасныг зөрчсөн Засаг даргыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно/

ДӨРӨВ. СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАН ЯВУУЛАХАД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Шинээр батлагдсан сонгуулийн тухай хуульд цагдаагийн байгууллагын үүрэг оролцоо, эрх хэмжээ, үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл боломжийн талаар тусгайлан зааж өгчээ.

Сонгуулийн хэрэг, зөрчлийн талаар иргэн, хуулийн этгээд нь гомдол, мэдээлэл цагдаагийн аль ч байгууллагад гаргаж болно. Сонгуулийн тухай хуульд сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болох эрхийг ч тодорхой тусгасан байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг цагдаагийн байгууллага нь захиргааны хариуцлагын тухай болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан хугацаанд шалгаж, цугларсан баримт материалыг шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлнэ.

Сонгуулийн тухай хуульд заасан захиргааны бүх зөрчлийг цагдаагийн байгууллага шалгах бөгөөд сонгуультай холбоотой шүүхэд шууд ирүүлсэн гомдол мэдээлэлд дурьдсан үйл баримт, нотлох баримтыг шалгуулахаар шүүхээс өгсөн даалгаврыг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ.

Түүнчлэн сонгуулийн сурталчилгааг радио, телевизээр нэвтрүүлэхэд гарсан зөрчлийг нэн даруй зогсоох үүргийг Харилцаа холбооны зохицуулах хороо, сонгуулийн байгууллага, мэргэшсэн төрийн бус байгууллагатай хамтран цагдаагийн байгууллага хэрэгжүүлж болох тухай тусгайлан заажээ.

Сонгуулийн үйл ажиллагааг хэвийн явуулах, сонгогч, сонгогчдын эрхийг хангах санал авах байрны хамгаалалт зэрэг сонгууль зохион байгуулахтай холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, цагдаагийн байгууллагын төсөвт тусгажээ.

Үүнд: цагдаагийн албан хаагчийн томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардал багтаж байгаа нь алба хаагчийн үүргээ хэвийн гүйцэтгэх эдийн засгийн багахан ч гэсэн баталгаа болж өгчээ.

Улсын Их Хурлын болон Орон нутгийн хурлын сонгуулийн үед цагдаагийн байгууллагын хийж гүйцэтгэх ажил нь:

- 1/ Сонгуулийн санал авах өдөр хүртэл,
- 2/ Санал авах байранд санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэл,
- 3/ Санал хураалт тоолж дуусснаас хойш гэсэн үндсэн гурван хэсэгт хуваагдана.

Сонгуулийн санал авах хүртэлх хугацаанд цагдаагийн байгууллага нь хариуцсан нутаг дэвсгэрийнхээ эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд тогтмол үнэлэлт дүгнэлт хийж, зохион байгуулалтын арга хэмжээ авах, бусад нэгж алба хаагчдыг мэдээллээр хангаж ажиллах шаардлагатай. Цагдаагийн байгууллагаас дараах ажил, арга хэмжээг авна.

Үүнд:

- Өмнө болсон сонгуулийн үеэр гарсан хэрэг, зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан эргүүлийн чиглэлийг оновчтой тодорхойлох, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж, гарын авлага боловсруулж, алба хаагч нэг бүрт танилцуулах,

- Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг зөрчлийг шалгах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг тушаалаар томилж ажиллуулах. Ажлын хэсэгт ажиллах алба хаагчдын албаны бэлэн байдлыг хангаж, үүрэг гүйцэтгэхэд дүрс бичлэгийн болон фото зургийн аппарат бусад шаардлагатай техник хэрэгсэл, автомашинаар хангах,

- Сонгуулийн сурталчилгааны болон санал авах ажиллагааны явцад бий болсон нөхцөл байдал, гэмт хэрэг, зөрчил, жагсаал цуглааны талаар нам эвсэл, нэр дэвшигч, сонгуулийн хороодоос гаргасан хүсэлт гомдол, мэдээллийг нэн даруй мэдээлж, мэргэжил арга зүйн чиглэлийг тухай бүр авч байх, хэрэг зөрчил, маргаан тэдгээрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар илтгэх хуудсаар мэдэгдэх, өдөр тутмын мэдээллийг тодорхой цагуудад өгч, нөхцөл байдлыг илтгэж байх,

- Сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой шалгагдаж байгаа хэрэг зөрчил материалын нууцлалыг чанд сахиж, мэдээ мэдээллийн талаар бусдад болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр задруулахгүй тараахгүй байх, /байцаалт, тайлбар мэдүүлгийг компьютерт хадгалахгүй нэн даруй хэвлэж бэхжүүлсний эцэст устгах/,

- Сонгуулийн сурталчилгааны байранд хулгай орох, гал тавих, эд зүйлийг эвдэх, сурталчилгааны материалыг урж тасдах, баллах, санал авах хуудсыг нуух, сонгуулийн хорооны гишүүд архи согтууруулах ундааны зүйл хэрэглэх, бусадтай хэрүүл, маргаан үүсгэх зэрэг зөрчлүүд гарч байсныг анхаарчдээрх нөхцөл байдал үүсэн үед ажиллах заавар, үүргээр алба хаагч нэг бүрийг хангах, санал авах байранд ажиллах алба хаагч нэг бүрийг нэрсээр нь томилгоожуулах,

- Хэрэг материал шалгахдаа хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх асуудлыг үндсэн зарчим болгож ажиллах,

- Сонгуулийн маргаан зөрчлөөс болж олон хүн цугларч нийтийн эмх замбараагүй байдал үүсч болзошгүй тул түүнээс урьдчилан сэргийлэх, жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 14-р зүйлийг хэрэгжүүлж ажиллана.

Сонгуульд дэвшигч нь сонгуульд оролцоходоо тус хуулийн 125.4.4-д зааснаар ял шийтгүүлж байгаагүй эсхүл ял шийтгүүлж байсан бол ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх шаардлагыг хангасан байх заалтыг хэрэгжүүлэхэд Цагдаагийн төв байгууллагын Мэдээлэл, технологийн төв “цагдаагийн байгууллагын тодорхойлолт”-ыг гаргаж өгнө. Мөн тодорхойлолтыг сонгуулийн хорооны хүсэлтээр ял шийтгэгдсэн эсэхийг тодорхойлж болно.

Дараах тохиолдолд ялшигчгүй гэж үзнэ.

а/ урьд нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдон, ял шийтгэл хүлээжбайгаагүй;

б/ тэнсэж хянан харгалзсан, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

в/ хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ялаа эдэлж дууссанаас хойш нэг жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

г/ хүндэтгэр гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш таван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

д/ хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш найман жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

е/ онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үндсэн ба нэмэгдэл ялаа эдэлж дууссанаас хойш арван жилийн дотор гэмт хэрэг шинээр үйлдээгүй;

ж/ үндсэн ба нэмэгдэл ял хүлээсэн этгээд аль алиныг нь эдэлж дууссан;

з/ шүүхээс тухайн этгээдийг хугацаанаас нь өмнө ял шийтгэлгүй гэж тооцсон. Дээрх ажиллагааг явуулахдаа ЦБҮАЖ-ын код 631-д заасны дагуу гүйцэтгэх ба энэ журмыг зөвхөн сонгуулийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Сонгуулийн үед хэв журмын хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн сонгох эрхийг хүндэтгэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах асуудлыг өмнөх өдрийн 09.00-20.00 цагийн хооронд авахаар сонгуулийн хуульд

зохицуулагдсан тул алба хаагчдын сонгох эрхийг хангах нөхцөл бололцоог цагдаагийн байгууллага олгоно.

Мөн цагдаагийн байгууллага нь захиргааны зөрчлийн улмаас баривчлагдсан, албадан саатуулагдсан, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан, байцаан шийтгэх албадлагын арга хэмжээний улмаас баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн сонгох эрхийг хангах зорилгоор зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар санал авах ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох тодорхойлолтыг гаргах, сонгогчийн хүсэлт саналыг шуурхай уламжлах, баривчлагдсан цагдан хоригдсон этгээдийн иргэний үнэмлэхийг хорих байгууллагын захиргаанд хүлээлгэн өгөхээрэг зохион байгуулалтын арга хэмжээ авна.

Санал авах хүртэлх хугацаанд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх бас чухал үүрэг бол сонгуулийн саналын хуудас хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх үйл ажиллагааны хамгаалалт юм.

***Кейс-1.** УИХ-ын 24-р тойргийн хороо 06.19-ний өдрийн 14:35 цагт Мөнхийн үсэг хэвлэлийн компанийн байрнаас саналын хуудсаа авах үед СЕХ, Нийслэлийн СХ, Тагнуулын ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын төлөөллүүд байлцсан. Саналын хуудсаа тойргийн хорооны ажилтнууд цагдаагийн хамгаалалттайгаар хүлээж авч аюулгүй байдлыг хангах зорилгоор цагдаагийн машин дагалдаж явсан. 24-р тойргийн хувьд цагдаагийн хамгаалалттай байсан бол 19-р тойрог цагдаагийн хамгаалалтгүй харин ЗДТГ-ын харуулын хамгаалалтад байсан. Аюулгүй байдлыг хангасан байдал нь хэсгүүдэд лацтай төмөр шүүгээнд хадгалах хэмжээнд хийгдэж, хамгаалалтад авсан байлаа.*

/Саналын хуудас хэвлэх, хадгалах, хамгаалах, хүргүүлэх архивт шилжүүлэх үйл явцын хяналтын дүн. Сонгогчдын Боловсрол Төвийн мониторинг 2012.07.05/

Дээрх баримтаас саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх үед хамгаалалт бүрэн авагдахгүй байх зөрчил дутагдал мэр сэр гарсан байгаа нь сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна гэж үзэх үндэстэй.

Саналын хуудас хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах ажлыг СЕХ-ноос байгуулсан ажлын хэсэг зохион байгуулж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хорооны гишүүд, ажлын албаны ажилтнууд, холбогдох бусад байгууллагын төлөөлөл оролцох бөгөөд саналын хуудсыг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө санал авах байранд хүргүүлсэн байхаар тооцож хэвлүүлэх⁶ ба саналын хуудасны эх бэлтгэх, хэвлэх, боож баглах, хүлээлцэх явцад хэвлэлийн ажилтнуудаас гадна ажлын хэсгийн хүмүүс, нам эвсэл, төрийн бус байгууллагын ажиглагч, харуул хамгаалалтын ажилтнаас өөр хүн байхыг хориглосон.

Сонгуулийн хороо саналын хуудсыг хүргүүлэх, хүлээн авах ажиллагааг цагдаагийн хамгаалалтын дор гүйцэтгэж, саналын хуудас санал авах байранд ирснээс хойш Санал авах байрны ахлах зохион байгуулагч нь бусад зохион байгуулагчийг байлцуулан саналын хуудаст тэмдэг дарж баталгаажуулна. Түүний дараа саналын хуудсыг боож, лацдан гал, усны болон гэнэтийн аюулд өртөхөөс урьдчилан сэргийлж, тус байрыг саналын хуудас ирснээс хойш санал авах, санал тоолж дуустал цагдаагийн байнгын хамгаалалтад авна.

⁶Саналын хуудсыг хэвлүүлэх хадгалах, хүргүүлэх хамгаалах журам. СЕХ-ны 2016 оны 17-р тогтоолын нэгдүгээр хавсралт

Кейс-2. Ховд аймгийн 16-р тойргийн Жаргалант сумын 35-р хэсгийн хороонд 1893 ш битүүмжилсэн саналын хуудас очихоос 3 ширхэг саналын хуудас дутсан, Зэрэг суманд 612ш хуудас очихоос 2 дутсан зөрчил өмнөх 2012 оны УИХ-ын сонгуулийн үеэр гарч байв.

Саналын хуудсыг хадгалах үүрэг бүхий албан тушаалтан түүнийг алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд цагдаагийн байгууллага, сонгуулийн тухайн шатны хороод болон СЕХ-нд нэн даруй мэдэгдэх тухай заалттай.

Санал авч дуусснаас хойш битүүмжлэгдсэн саналын хуудсыг аймаг, нийслэлийн архивт хүргүүлж өгөх хүртлэх ажиллагаа цагдаагийн хамгаалалтад дор явагдана.

Сонгуулийн хуулиар санал авах байрны хамгаалалтыг хариуцахаар хуульчилсан.

Санал авах байрны хамгаалалтыг зохион байгуулахад цөөнгүй зөрчил дутагдал гардаг бөгөөд онцгой анхаарах зарим асуудлууд байдаг.

Санал авах байранд хамгаалалт явуулахад шаардлага хангахгүй байр, цонхны хаалт байхгүй эсвэл эвдэрсэн, гэрэлтүүлэг хангалтгүй, гэрэл чийдэн нь шатсан эсхүл байхгүй, хаалганы цоож бэхэлгээ муу, зориулалтын лац ломбогүй, камержуулалтгүй, байрны цонхнуудад гадна талаас нь хяналт тавих боломжгүй, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг хүмүүс ихээр цугларладаг, хөдөө орон нутагт цахилгааны эх үүсвэргүй, байрны дээвэр муу, борооны дусаал гоожих, цахилгааны шугам сүлжээ аюулгүй байдлын шаардлагыг хангаагүй зэрэг нь цагдаагийн бүрэн хамгаалалтад авахад тохиромжгүй, хамгаалалтыг явуулахад хүндрэлтэй байрууд байдаг. Тийм ч учраас аюулгүй байдлын хамгаалалт, төлөвлөлтийг урьдчилан гаргасан байх ёстой.

Санал авах байрны хамгаалтыг зохион байгуулахдаа Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 627-д заасан “Сонгуулийн санал хураах байр хамгаалах” журмыг баримтлан ажиллана.

Тус журамд зааснаар санал байранд хэв журам хамгаалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй бөгөөд хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь хариуцан ажиллаж байгаа хэсгийн хороо, түүний удирдлагаас хараат бус байна. Санал авах байранд хамгаалтын үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр солих, өөр үүрэг гүйцэтгүүлэхээр томилохыг хориглоно. Мөн сонгуулийн бусад ажиллагаанд оролцохгүй байх зарчмыг баримтална.

Сонгуулийн санал авах байруудын жагсаалтыг үндэслэн хэв журмын хамгаалалтын зураглал, төлөвлөгөө, үүрэг гүйцэтгэх алба хаагчийн хуваарь, үүрэг гүйцэтгэсэн тухай рапорт, хүлээлцэх эд зүйлсийн бүртгэл, шаардлагатай үед хүч нэмэгдүүлэн ажиллах төлөвлөгөөг гаргах зэргийг гаргана.

Сонгуулийн санал авах байр, ажилтныг ажиллах боломж нөхцөлөөр хангах сонгуулийн хороодын байршилд автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг суурилуулахад⁷ шаардлагатай зохих хэмжээний талбай, цахилгаан эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ бүхий өрөө тасалгаагаар хангах асуудлыг тухайн баг хорооны Засаг дарга шууд хариуцахаар сонгуулийн тухай хууль тогтоомжид заасан ба санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлыг ч төсөвт тусгайлан суулгаж өгсөн.

Тиймээс санал авах байрны хамгаалалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байр бэлтгүүлэх, түүнд нэмэлт засвар үйлчилгээ хийлгэх талаар Засаг даргад санал гаргаж, шийдвэрлүүлэх нь хамгаалалтын чанар, үр дүнд шууд нөлөөлнө.

Санал авах байрыг санал авах өдрөөс 10 хоногийн өмнө байрны байршил, орчин тойрны дэвсгэр зураг планыг нийтэд зарлан мэдээллэхээр хуульд заасны дагуу санал

⁷Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 16.1.Бүх шатны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрт ажиллах сонгуулийн хороодын байршилд автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг суурилуулахад шаардлагатай зохих хэмжээний талбай, цахилгаан эрчим хүч, мэдээлэл, харилцаа холбооны сүлжээ бүхий өрөө тасалгаагаар хангах асуудлыг хариуцан шийдвэрлэх үүрэг хүлээнэ.

авах байрны эргэн тойронд аюулгүй байдлыг хангах зорилгоор объектын болон субъектын судалгааг явуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

Санал авах байрны байршилд үерийн аюул болж болзошгүй байдлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран урьдчилан судална. Түүнчлэн нийтийн эмх замбараагүй байдал, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас аюулд өртөгдөх, болзошгүй бодит бусад аюул байвал санал авах байрны байрлалыг өөрчлөх тухай саналыг харьяалах Засаг дарга, сонгуулийн хороонд орон нутгийн цагдаагийн байгууллагаас гаргаж болно.⁸

Санал авах байранд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч нь сонор сэрэмжтэй, анхааралтай үүрэг гүйцэтгэж, санал авах байрны аюулгүй байдалд хяналт тавьж, тэнд ажиллаж байгаа ажилтнуудыг тарахад нь байрыг цоожлуулан лацдуулж хүлээн авах ба ажилдаа ирэх үед нь хүлээлгэн өгнө. Шөнийн цагаар хэсгийн хорооны байр, түүний ойр орчмыг байнгын давтамжтай эргэж шалгана.

Санал авах байранд суурин болон зөөврийн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал тоолох төхөөрөмж, дагалдах хувилах хэвлэх хэрэгсэл, компьютер, сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг, сонгогчийн бүртгэл дэх зургийг нийтэд болон ажиглагчид үзүүлэх дэлгэц зэрэг санал авахад шаардлагатай бусад эд зүйлс байна.

Санал авах байранд санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэлх ажиллагаа

Санал авах ажиллагаа явагдаж байгаа үед саналын байранд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны итгэмжлэгдсэн ажилтан /гарын хээ шалгах, иргэний бүртгэлийн мэдээллийн улсын сан дах нэрийн жагсаалтыг тулган үзнэ/сонгуулийн хорооны ажилтнууд байхаас гадна сонгуулийн ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно. Санал авах байранд нэр дэвшигч болон бусад этгээд байхыг хориглоно. Харин тэдгээрээс саналаа өгөхөд хамаарахгүй.

Санал авах байрны хамгаалалтад анхаарах бас нэгэн зүйл бол санал авах хугацаа юм. Урьд нь сонгуулийн санал авах хугацаа орон нутгийн цагаар явагдаж байсан бөгөөд сонгуулийн дүн хугацаандаа нэгтгэгдэхгүй байх зэрэг зөрчил, будлиан гарч байсантай холбогдуулан санал авах хугацааг Улаанбаатарын цагаар тооцож, 07.00-22.00 цагийн хооронд явагдах болсон.

Саналын хугацаа 22.00 цагт дуусч, сонгогчдын бүртгэл зогсох боловч энэ хугацаанд бүртгэлийн хуудсаа авсан сонгогчдын саналаа өгөх боломж энэ удаагийн хуулиар хангагдсан. Энэ цаг хугацаатай давхцаж санал авах байрны гадаа саналаа өгөхөөр ирсэн хүмүүс орох гэж дайрах, хүмүүсийн бөөгнөрөл үүсэх, хэрүүл маргаан гарах зэрэг нөхцөл байдал үүсдэг учраас тухайн цагт санал авах байранд хамгаалалтын хүчийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

Кейс-3. Ард иргэдийг сонгуульд идэвхтэй оролцуулахын тулд энэ өдрийг бүх нийтийн амралтын өдөр гэж зарлаж, олон нийтийн газруудыг хааж, архи согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглосон. Гэтэл Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг “Cheers” кафе, “Наран” хүнсний дэлгүүр нууцаар архи зарж иргэдэд үйлчилж байсан зөрчил гарч байсан.

⁸Сонгуулийн тухай хуулийн 87.8.Санал авах байр санал авах өдрөөс арав хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ийг нийтэд зарлан мэдээлнэ.

87.9.Санал авах байрын байршлыг нийтийн эмх замбараагүй байдал, үер ус, гал түймэр зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас өөрчилж болох бөгөөд энэ тухай нэн даруй сонгогчид мэдээлнэ.

Санал авах өдөр архи согтууруулах ундаа зарж борлуулахгүй, томоохон худалдааны газар, үзвэр үйлчилгээний газрууд ажиллахгүй тул энэ талаар хариуцсан нутаг дэвсгэрт хяналтыг сайжруулж, мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран эргүүл шалгалтыг явуулна. Согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх талаар урьдчилан аж ахуйн нэгж, байгууллагад албан ёсоор мэдэгдэх ажлыг зохион байгуулна.

Сонгуулийн үеэр гардаг хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, шалгахад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг ойлгохгүйгээр асуудалд бодиттой шуурхай хандан гэж үзэх үндэсгүй тул Сонгууль зохион байгуулахтай холбоотой хууль тогтоомж, бусад эрхийн актуудыг урьдчилан сайтар судлах шаардлагатай.

Цагдаагийн алба хаагч нь хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэхдээ сонгогч, сонгогчдын эрхийг хүндэтгэн, сонгуулийн сурталчилгаанд оролцохгүй байх, аливаа асуудалд төрийн албан хаагчийн байр сууринаас тэвчээртэй, хүлээцтэй хандаж, хэрэг маргааныг хууль зүйн дагуу шийдвэрлэж байх нь зүйтэй.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасанчлан жагсаал, цуглааныг дараах тохиолдолд албадан тараана.

1/ Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлээгүй бол;

2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, хуулиар хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;

3/ шүүхийн болон эрх бүхий бусад байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогсоогдсон буюу татан буугдсан, эсхүл албан ёсны бүртгэлгүй улс төрийн нам, төрийн бус байгууллага жагсаал, цуглаан хийх мэдэгдэл гаргасан бол;

4/ дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;

5/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох;

6/ нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол;

7/ жагсаал, цуглаан хийхийг бүртгэсэн, эсхүл харьяалах нутаг дэвсгэр дээр нь бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулагдаж байгаа засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга бий болсон нөхцөл байдлыг жагсаал, цуглаан зохион байгуулагчид мэдэгдэж, 2 цагийн дотор түүнийг тараахыг бичгээр шаардана. Шаардлага авсан зохион байгуулагч жагсаал, цуглааныг сайн дураар тараахаас татгалзсан буюу татгалзаагүй боловч уг үйл ажиллагааг дурдсан хугацаа өнгөрсний дараа цаашид үргэлжлүүлбэл жагсаал, цуглааныг цагдаагийн байгууллага хуульд заасан арга, хэрэгслээр албадан тараана.

ТАВ. СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙГ ШАЛГАХАД АНХААРАХ АСУУДАЛ

Сонгуулийн тухай хууль тогтоомжид нийт 74 зүйлд 136 зөрчил заагдсан ба зөрчлийн шинж байдал, хэлбэр, төрлөөс нь хамааруулан хэд хэдэн хэсэгт бүлэглэн авч үзэж болно.

а/ Сонгуулийн эрх, сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэс, сонгууль зохион байгуулах эдийн засгийн үндэстэй холбоотой зөрчил

Сонгуулийн үндсэн зарчим нь иргэд нийтээрээ чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр саналаа нууцаар гаргах, түүнийг хангахад чиглэгдэх ёстой. Тийм учраас сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие дааж шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулж болохгүй, сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.

Тэдгээрийг зөрчиж байгаа аливаа үйлдэл, эс үйлдэлд тус хуулийн 4.6-д заасны дагуу торгох арга хэмжээ авах бөгөөд дээрх заалтыг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл, эс үйлдэлд эрүүгийн гэмт хэргийн шинжгүй бол төрийн албанд эргэж орох эрхгүйгээр халахаар заасан байна.

Сонгуулийн эрхтэй холбоотойгоор сонгуулийн эрх бүхий иргэний сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглосон.

б/ Сонгуулийн тойрог, хэсэг, сонгуулийн байгууллага

Сонгуулийг сонгуулийн байгууллага зохион байгуулж явуулах бөгөөд түүний дотоод үйл ажиллагааны журамд Сонгуулийн хороо эрх хэмжээнийхээ асуудлыг нийт бүрэлдэхүүний гуравны хоёроос доошгүй ирцтэй хуралдаанаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийнхээ ердийн олонхийн саналаар шийдвэрлэж, гарсан шийдвэрт дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй ба хэрэв татгалзвал тухайн эс үйлдэл нь зөрчилд тооцогдоно.

Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтныг сонгуулийн холбогдолтой чиг үүргээ хэрэгжүүлж байхад нь үндсэн ажлаас нь чөлөөлөх, огцруулах, өөр ажил, албан тушаалд шилжүүлэх, цалинтай чөлөөг нь олгохгүй байхыг хориглох ба сонгуулийн байгууллагын ажилтан нь сонгуулийн сурталчилгаа явуулах, дэмжсэн болон эсэргүүцэх, санал хураах тоолох ажилд саад хийх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, бусдыг төлөөлж санал өгөх, шат шатны сонгуулийн хорооны шийдвэрийг биелүүлэхгүй байх үйлдэл, эс үйлдэхүй нь мөн зөрчилд тооцогдоно.

в/ Сонгууль зохион байгуулах зардал, хандив, сонгуулийн зардлын хяналт, тайлан

Сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх ба зардлыг нэг бүрчлэн зааж өгсөн байдаг. Харин тодорхой албан тушаалтнаас тухайлбал, санал авах байрыг төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд үнэ төлбөргүй гаргах заалтыг зөрчих, тухайн шатны Засаг дарга байр, тээвэр холбоо, болон бусад шаардлагатай хэрэгслээр үнэ төлбөргүй хангах заалтыг зөрчсөн үйлдэлд хариуцлага тооцно.

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч нь мөрийн хөтөлбөрөө сурталчлах зорилгоор сонгуулийн сурталчилгааны зардал гаргана. Уг зардал нь хандив, намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс бүрдэнэ. Зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн дансанд төвлөрүүлж, сурталчилгаа, уулзалт, хурал цуглаан, бичиг хэрэг, шуудан холбоо унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг зориулалтын дагуу зарцуулна. Зөрчсөн тохиолдолд хариуцлага оногдуулна.

Иргэн буюу хандивлагч нь Монгол Улсын иргэн байна. Иргэн, хуулийн этгээд нэг нам, эвсэл, нэр дэвшигчид жилд нэг удаа л хандив өгч болохоор хуульчилсан. Хандив нь мөнгөн, мөнгөн бус хэлбэртэй байхын зэрэгцээ мөнгөний хэмжээ нь иргэн 3 сая төгрөг,

хуулийн этгээд 15 сая төгрөг хүртэл байна. Бэлэн мөнгөөр хуулийн этгээдээс хандив авахыг хориглоно. Мөнгөн бус хандивт үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх хамаарах бөгөөд заавал гэрээ байгуулна. Хандивыг дараах этгээдээс авахыг мөн хориглосон. Үүнд: гадаад улс буюу гадны байгууллага, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, 18 нас хүрээгүй хүн, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны зээлийн хугацаа хэтэрсэн өртэй этгээд, үйлдвэрчний болон шашны төрийн бус байгууллага, байгуулагдаад 1 жил болоогүй хуулийн этгээд, хандив өгсөн этгээдийн эрх зүйн байдал тодорхойгүй зэрэг болно.

Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн тухай хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа гаргана. Хэрэв зардлын тайлангаа ирүүлээгүй бол хариуцлага оногдуулна.

г/ Сонгогчдын нэрийн жагсаалт

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой зөрчил маргаан нилээд гардаг. Уг хуулиар сонгогчийн нэрийн жагсаалт нь цахим болон цаасан хэлбэртэй байх ба сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэж, цахим хуудаст байрлуулахаар заажээ.

Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмыг зөрчих үйлдэл нь улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтнуудтай шууд холбоотойгоор илрэн гарна.

Тухайлбал, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гаргасан гомдлын дагуу оруулсан өөрчлөлт, сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хүйс, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийн өөрчлөлт зэрэг иргэний бүртгэлтэй холбогдсон өөрчлөлт, цэргийн алба хааж байгаа сонгогчтой холбогдсон өөрчлөлт, нас барсан иргэний бүртгэлтэй холбогдсон өөрчлөлтийг сонгогчдын нэрийн жагсаалтад оруулаагүй, санал авах байрын албан ажлын хэрэгцээнээс бусад тохиолдолд сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж олшруулах, тараах, энэ хуульд заасныг зөрчин сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулсан нь зөрчилд тооцогдоно.

д/ Сонгуулийн сурталчилгаа

Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна:

- сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;
- нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;
- хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах;
- сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;
- ухуулах байр ажиллуулах;
- радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;
- цахим хуудас ашиглах замаар сурталчилгааг явуулж, сурталчилгааг санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно.

Сурталчилгааны аливаа материалын доод хэсэгт захиалсан этгээдийн эх сурвалж, захиалагчийн нэрийг тодорхой харагдахуйц товчлохгүй бичнэ. Энэ нь телевизийн нэвтрүүлгийн нийт хугацаанд хамаарах ба радиогийн нэвтрүүлгийн тухайд эхлэл, төгсгөлд захиалагчийн нэрийг дурдана. Сурталчилгаанд тээврийн хэрэгсэл ашиглаж болох бөгөөд сонгуулийн хороонд бүртгүүлэн нэгдсэн таних тэмдэг авч, авто машин, автобусны салхины шилний баруун доод буланд, мопед, мотоциклын шатахуун хадгалах савны баруун талд нааж байрлуулна.

Кейс 4. “Ариун ертөнц” нийгэмлэгийн тэргүүн Т-ээс “НЭМГ-ын дарга Ту нь 2012.6.07-ны өдөр дүүргүүдийн бүх эмнэлэгийн 30 орчим дарга нарыг өрөөндөө цуглуулан МАН-аас нэр дэвшигчид хандив өгөх хэрэгтэй

байна гээд нэг эмнэлэгээс 500,000 төгрөг хандив болгон авсан байна. Үүнийг шалгаж өгнө үү” гэсэн өргөдөл ирүүлснийг ЧД-ийн ЦХ-т шалгасан.

Кейс-5. Увс аймагт УИХ-ын сонгуулийн 15-р тойргийн хорооноос ухуулагч нар Г, Ч нарт мөнгө өгч Н, М нарыг дэмжээрэй гэж 100,000 төгрөг өгсөн, иргэдэд сүү, 5000 төгрөг өгсөн зэрэг зөрчил гарч байжээ.

Санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор:

Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээнд хөнгөлөлттэй болон төлбөргүй үйлчлэх;

Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх, сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амраах, сувилуулах;

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах;

Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх, хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;

Шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах, сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг, материалд шашны холбогдолтой аливаа дуу, зураг хэвлэх, нийтлэх, нэвтрүүлэх;

Сонгогчдын саналыг татах зорилгоор өөрөө болон бусдаар дамжуулан, эсхүл хүмүүнлэгийн, буяны, шашны байгууллага болон төрийн бус байгууллага, сангийн нэрээр халхавчлан сонгогч, түүний гэр бүлийн гишүүн, насанд хүрээгүй хүн, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, цалин хөлс, урамшуулал, тэтгэлэг олгох;

Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, хүмүүнлэгийн, буяны болон шашны байгууллага, санал авах байр болон сонгуулийн байгууллагын ажиллах байранд сонгуулийн сурталчилгаа явуулах;

Санал авах өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд нам, нэр дэвшигчдийн талаар санал асуулга явуулах, энэ төрлийн мэдээллийг бүх төрлийн мэдээллийн хэрэгсэл ашиглан нийтлэх, тараах, сонгуулийн штаб, түүний ажилтан, менежер, шадар туслагч, ухуулагчаас бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийх;

Хуульд зааснаас өөр арга, хэлбэр, зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх, сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах, төрийн болон бусад өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын чанартай ажил, үйлчилгээ явуулах;

23.00 цагаас дараа өдрийн 07.00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах, сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;

Сурталчилгаанд улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч аливаа хэлбэрээр оролцох, хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах;

Сонгуулийн сурталчилгааны явцад бусдыг гүтгэх, доромжлох, гутаах, хуурамч мэдээ, мэдээллийг төрөл бүрийн хэлбэрээр тараах, сонгогчид эдийн болон эдийн бус давуу байдал олгох, олгохоор амлах, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд

тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон амлалтыг сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тусгах, амаар болон өөр хэлбэрээр сонгогчдын дунд түгээн дэлгэрүүлэх;

Сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах, эх сурвалжийг дурдаагүй сонгуулийн сурталчилгааны материалыг хэвлүүлэх, тараах, нийтлэх, нэвтрүүлэх;

Хэвлэл мэдээллийн байгууллага нь сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуульд оролцогч аль нэг талын талаар бүх төрлийн мэдээ, мэдээлэл гаргах, гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулах;

Дахин болон нэмэлт санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн сурталчилгаа хийх;

Кейс-6. СХД-ийн 1-р хороолол зам дагуу байрлуулсан 200 орчим сурталчилгааны самбарыг хулгайд алдсан тухай гомдол, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын АН-ын хороо нь МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 35.1 дэх заалтыг зөрчиж, сумын сонгуулийн I хэсэгт зөвшөөрөгдсөн тооноос илүү зурагт самбар байрлуулж сурталчилгаа явуулсан гэх гомдол цагдаагийн байгууллагад иржээ.

Шийдсэн нь: Аймгийн сум дундын 1-р шүүхэд 2013.06.19-ний өдөр 1398 тоот албан бичгээр шилжүүлсэн. Шүүхээс 2013.06.19-ний өдөр 161 тоот захирамжаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 35.2-д зааснаар 421200 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, зурагт хуудас болон бусад сурталчилгааны материалыг санаатайгаар устгах, бохирдуулах;

Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгааны хугацаанд гадаад улсын иргэн, хуулийн этгээдийн зөвлөгөө, тусламж, дэмжлэгийг шууд болон шууд бусаар хүлээн авахыг хориглоно.

Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал хурааж дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг хориглох бөгөөд сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэх, сонгуулийн сурталчилгаа хийх эрх бүхий этгээдэд хариуцлага хүлээлгэхийн тулд тэдгээрийн нэрийн өмнөөс хууль бус сурталчилгаа хийх зэрэг олон үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцохоор хуульчилсан байна.

Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааг нам, эвслийн болон нэр дэвшигчийн сонгуулийн штаб эрхлэн явуулна. Хоёр буюу хэд хэдэн бие даан нэр дэвшигч нэгдэн сонгуулийн штаб байгуулахыг хориглоно. Сонгуулийн нам, эвслийн штабын бүрэлдэхүүнд нам эвслийн дарга, ажилтан нар, нэр дэвшигчийн штабт менежер, шадар туслагч, ухуулагч ажиллах бөгөөд тэдгээр нь бүгд сонгуулийн байгууллагаас олгосон үнэмлэхтэй байна. Сурталчилгааны хэвлэмэл материал нь нэр дэвшигчийн, нам, эвслийн гэсэн төрөлтэй байна. Гудамж талбайд байрлуулсан сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах хуудас, самбарыг хууль бусаар устгах, гэмтээх, бохирдуулах, намын далбааг ухуулах байр, нэр дэвшигчийн сурталчилгааны самбар, сонгуулийн сурталчилгаанд ашиглах зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслээс өөр бусад газар байрлуулахыг хориглоно.

Тухайн шатны Засаг дарга, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь сонгуулийн сурталчилгааны уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн тамирын, хурлын болон бусад байр, танхимыг гаргаж өгөх, үнэ төлбөргүйгээр ашиглуулах, дэмжлэг үзүүлж, сонгуульд оролцогч талуудад тэгш хандах үүрэгтэй.

Сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэх, радио, телевизээр улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа

хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, сурталчилгааг явуулахдаа бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг хориглосон.

Кейс-7. УИХ-ын гишүүн Д.Ганхуягаас “нэр бүхий 15 вэб сайт дээр үндэслэлгүй гүтгэлэг гарсан байна үүнийг зогсоож өгнө үү” гэх өргөдөл БЗД-ийн ЦХ-т ирүүлснийг шалгасан.

Шийдвэрлэлт нь: Ташаа мэдээлэл *uls.mn* сайтад тавигдсан болох нь тогтоогдож, мэдээллийг гаргасан С-ийг ажлаас нь халж, Улс.мн сайт нь албан ёсоор уучлал гуйж, талууд эвлэрсэн тул ЭХҮТ шийдвэрлэжээ.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Сонгуулийн тухай хуулиар сурталчилгааг явуулах хугацаа 17 хоногоор тогтоосон нь урд үйлчилж байсан хуулийн сурталчилгааны хугацаанаас богино байгаа учир ихэнх сурталчилгааг интернэт орчин ашиглан явагдах урьдчилсан таамаглал байна. Иймд цахим сүлжээгээр бусдыг гүтгэх, доромжлох болон аливаа хууль бус үйлдэл явагдаж болзошгүй бөгөөд интернэтээр сурталчилгааг явуулахдаа захиалагчийн нэр, эсхүл тэдгээрийн сонгуулийн штабын нэрийг заавал дурдахаар заасан байгаа.

Дээрх зөрчлүүд нь сонгуулийн сурталчилгааны үеэр хамгийн их гардаг зөрчлүүд бөгөөд зөрчлийг шалгахдаа цагдаагийн байгууллагын албан хаагч нэг талыг барихгүй, өөрөө улс төржихгүй, өөрийн үзэл бодлыг гол болгохгүйгээр үнэн бодит байдлыг тогтоож шалгана.

е/ Санал авах үйл ажиллагаа

Сонгогчийн саналыг авах ажиллагаанд зөрчил багагүй гардаг бөгөөд уг ажиллагаанд гарч буй зөрчлийг сонгогч санал өгөх, санал тоолох үед гарах зөрчил гэж ангилан үзлээ.

Санал авах байранд нэр дэвшигч нь саналаа өгөхөөс бусад тохиолдолд болон зөвшөөрөлгүй этгээд байхыг хориглосон нь санал авах байрны хэвийн үйл ажиллагааг хангахад шууд чиглэгдэж байна.

1/ Сонгогч санал өгөх.

Сонгогч санал авах байранд өөрийн биеэр ирж, саналаа биечлэн өгөх ба дараах зүйлийг хориглоно:

Тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, өөр хүний бичиг баримт, эсхүл хуурамч бичиг баримт ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох;

Тухайн санал авах байрны олгосноос өөр саналын хуудсыг санал өгөхөд ашиглах, санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, санал авах байрнаас саналын хуудас авч гарах;

Саналын хуудаст тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх зэрэг үйлдэл хийх, саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах;

Альнэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсхүл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авахыг хориглосон бөгөөд зөрчсөн иргэн, холбогдох бусад этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулахаар хуульчилсан байна.

Дээрх зөрчлийг шалгахад онцгойлон анхаарах зүйл бол гэмт хэргийн шинж байгаа эсэхийг сайн нягтлана.

2/ Санал тоолох ажиллагаа

Санал тоолох ажиллагааг санал авах ажиллагаа дуусмагц эхэлнэ. Ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчийг санал авах байранд байлцуулан ил тод, нээлттэй явуулна.

Санал авах байранд хэсэг тойргийн хороонь санал тоолох ажиллагааг гүйцэтгэхээс өмнө дараах ажиллагааг хийж тэмдэглэл үйлдэнэ.

-Санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа

өгсөн сонгогчдын тоо нь сонгогчдод олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, тооцоо гаргах;

-Санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэлд тусган битүүмжилсний дараа саналыг тоолно.

Санал авах, тоолох төхөөрөмжид гэмтэл, саатал гарсан тохиолдолд тухайн төхөөрөмжид байгаа саналын хуудсыг хоёр дахь, эсхүл нөөц төхөөрөмжид уншуулж тоолох ба санал авах, тоолох төхөөрөмж байхгүй тохиолдолд сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу гар аргаар тоолно.

Санал авах байр санал тоолох төхөөрөмжөөс санал хураалтын дүнгийн хуудсыг хэвлэж авсны дараа санал хураалтын үр дүнгийн мэдээллийг сонгуулийн төв байгууллагад нэн даруй дамжуулна.

Санал авахад зарцуулсан болон зарцуулаагүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн санал авах байр хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл санал авах байр шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд шаардлагатай гэж үзвэл саналын хуудсыг нэн даруй дахин тоолно.

Саналын хуудас дахин тоолох үед зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, саналын хуудас тоолоход оролцсон сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн гарын үсэг зурна.

Дээрх процесс ажиллагааг журмын дагуу явуулаагүй байдал нь зөрчилд тооцогдох учраас гомдол, мэдээллийг шалгахдаа санал тоолох журмыг дарааллын дагуу хэрхэн гүйцэтгэсэн хэн ямар оролцоотой байсан зэргийг нягтлан тогтооно. Санал авах байранд нь ихэвчлэн хяналтын бичлэг хийгддэг болсон болохоор тухайн бичлэгийг нотлох баримт болгож материалд хавсаргах шаардлагатай.

ё/ Ажиглагч

Нам, эвсэл,бие даан нэр дэвшигч нь сонгуулийн ажиглагч /цаашид “ажиглагч” гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй. Ажиглагч нь арван найман нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна. Харин төрийн албан хаагч ажиглагч байхыг хориглоно. Ажиглагчийн эрх нь ажиглагчийн үнэмлэх авснаар эхэлж, сонгуулийн албан ёсны дүн гарснаар дуусгавар болно.

Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж санал авах байрны ажилд хөндлөнгөөс оролцвол санал авах байрны ахлах зохион байгуулагч ажиглагчийн бүртгэлийг хүчингүй болгон, үнэмлэхийг нь хураан авч, санал авах байраас гаргана. Санал авах байрны багтаамжаас хамаарч ажиглагч томилох эрх бүхий этгээдийн томилсон бүх ажиглагч санал авах өдөр санал авах байранд ажиглалт хийх боломжгүй бол санал авах байр хоёроос доошгүй ажиглагчийг санал авах байранд ээлжлэн ажиглалт хийх боломжоор хангах үүрэгтэй.

Ажиглагч сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн тухай хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглана.

Ажиглагч хуульд заасан дараах эрх эдэлнэ:

Сонгогчдын болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарь, саналын хуудасны битүүмжлэгдсэн байдал, санал авах, тоолох явцыг ажиглах;

Санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

Санал авах байранд санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх, санал авах үйл явцад зөрчил гарвал санал авах байрны ахлах зохион байгуулагчид

мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, баримтжуулах, гэрчээр гарын үсэг зуруулах, дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;

Санал авах байрны ахлах зохион байгуулагчаас холбогдох мэдээлэл авах, сонгуулийн байгууллагын үйл ажиллагааг ажиглах, ажиглалтын тайлангаа нийтэд мэдээлэх, хэвлэн нийтлэх, саналын хуудасны зурган болон тоон үзүүлэлтийг цахим хэлбэрээр хуулбарлан авах эрх эдэлнэ. Эдгээр эрхээ эдлэхэд нь санал авах байранд үйл ажиллагаа явуулж байгаа сонгуулийн ажилтан болон аливаа этгээд саад учруулж болзошгүй, тэдгээр нь зөрчилд тооцогдоно.

**ЗУРГАА. ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ЗААСАН ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ХЭРЭГ БҮРТГЭЛТ, МӨРДӨН БАЙЦААЛТЫН
АЖИЛЛАГАА ЯВУУЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Сонгуультай холбогдох гэмт хэргийн тухай ерөнхий ойлголт

“Иргэдийн улс төрийн болон бусад эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” гэсэн эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэгт Цагдаагийн байгууллагад харьяалуулсан сонгуультай холбогдох 3 гэмт хэрэг бий. Тухайн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо, иргэдээс хүлээн авч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шийдвэрлэнэ

130 дугаар зүйл. Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саадхийх

130.1.Иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

130.2.Энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, санал худалдаж авах зэрэг аргаар үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

Гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тогтооход анхаарах асуудал

Иргэн сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай, бодитой саад хийсэн идэвхитэй үйл ажиллагаа үйлдэл, эс үйлдэхүй нь энэ гэмт хэргийн объектив тал байна. Энэ төрлийн гэмт хэрэгт голлон анхаарах асуудал бол идэвхтэй үйлдлийг анхаарна.

Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн талаар Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор УДШ-ээс тайлбар гаргасан байдаг. Үүнд: Иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай саад хийх гэсэн 2 объектив талын үйлдлийг дараах байдлаар тайлбарлажээ.

Сонгох, сонгогдох болон бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд “саад хийсэн” гэдэгт Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуульд тусгайлан заасан хориг, хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэний дээрхэрхийг аливаа хэлбэрээр эдлүүлэхгүй байгаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/ -г ойлгоно

Сонгуулийн хорооны ажиллагаанд “саад хийсэн” гэж хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллагыг үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/ -г хэлнэ.⁹

Харин сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд санаатайгаар саад хийсэн үйлдлийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах санал

⁹Монгол Улсын дээд шүүхээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарласан

худалдаж авах аргаар хийсэн бол хүндрүүлж үзэхээр хуульчилсан. Бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийлэл нь “хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлэх”-д хамаарах бөгөөд энэхүү хүчирхийлэл нь үг хэлээр болон биет байдлаар үзүүлсэн идвэхтэй үйлдлээр илэрнэ. Заналхийлэх нь гэмт үйлдлээ хийхийн тулд сэтгэл санааны болон биеийн хүчирхийлэл үзүүлэх болон бусдыг алах, гэмтэл учруулах, эд хөрөнгийг устгах, хууль ёсны эрх ашгийг зөрчих, нэр төрийг нь гутаах, хувийн нууцыг задруулна гэж сүрдүүлэх хэлбэртэй байж болно.

“Хуурч мэхлэх”¹⁰ гэдэг нь “үгээр болон үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэх”-ийг, “Санал худалдаж авах” гэдэгт иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсхүл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эсхүл эд хөрөнгийн давуу эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн, эд мөнгөөр татах гэдэгт сонгогчид эд мөнгө өгөхөөр амласан зэргийг хамааруулна.

Энэ гэмт хэрэг нь сонгуулийн тухай хуульд заасан зарим зөрчилтэй хэлбэрийн хувьд ижилхэн бөгөөд тэдгээрээс ялгагдах гол шинж нь субъектив талын буюу сонгуулийн хорооноос зохион явуулж байгаа бүх төрлийн аливаа ажиллагаанд, иргэний сонгох сонгогдох эрхээ эдлэхэд бодиттой саад учруулснаас хор уршиг үүссэн, санаатайгаар саад хийж байгаа үйлдлээ ухамсарлаж, түүнийг хүсч үйлдэж байгаагаараа ялгаатай зүйчлэгдэнэ. Иймд ямар зорилгоор үйлдснийг нарийн тогтоож гэмт хэрэг зөрчлийг ялгана.

Субъектив тал нь гэм буруугийн шууд санаатай, иргэдээс сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд саад хийх гэсэн тусгай зорилготой байдгийг онцгой анхаарах хэрэгтэй.

130¹ дүгээр зүйл. Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх

130¹.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Орон нутгийн Хурлын сонгууль, ард нийтийн санал асуулгад оролцох үед санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах зорилгоор саналын хуудас ашиглан нэгээс илүү удаа санал өгсөн, эсхүл нэгээс илүү удаа санал өгөхийг санаатайгаар зохион байгуулсан бол гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ зүйлийг 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/

Энэ гэмт хэргийн объект нь иргэний сонгох, сонгогдох эрх, сонгуульд санал өгөх талаар хуулиар тогтоосон журам байна.

Энэ хэргийн гэмт үйлдэл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон УИХ, орон нутгийн сонгууль, ард нийтийн санал асуулгад оролцох үед санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах зорилгоор:

- Саналын хуудас ашиглан нэгээс илүү санал өгөх,
- Нэгээс илүү санал өгөхийг санаатайгаар зохион байгуулсан идэвхитэй үйл ажиллагаа-үйлдэл байна.

Сонгуулийн автоматжуулсан системээр сонгогч нь нэгээс илүү санал өгөх боломжгүй болсон ийм учраас энэ гэмт хэргийг сонгуулийн үйл ажиллагаа зохион явуулж байгаа ажилтнуудаас л зохион байгуулалттайгаар үйлдэх боломжтой

Тухайн хэрэгт хариуцлага ногдуулэх этгээд нь хууль бусаар илүү санал өгсөн, илүү санал өгөх үйл ажиллагааг санаатай зохион байгуулсан тодорхой гэм буруутай, хэрэг хариуцах чадвартай, насанд хүрсэн хэн ч байж болно.

Субъектив тал нь санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах гэсэн зорилготой, шууд санаатай хэлбэртэй байна.

¹⁰Улсын дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т зааснаар

131 дүгээр зүйл. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах

131.1. Сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, бусад албан тушаалтан сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3-т заасныг ноцтой зөрчиж санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан, 57.4-т заасныг ноцтой зөрчиж буруу шийдвэрлэсэн, мөн сонгогчоос санал нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлсөн бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасч, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

/Энэ хэсэгт 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

Энэ гэмт хэргийн объект нь иргэдийн сонгох, сонгогдох эрх, бүх шатны сонгууль, бүх нийтийн санал асуулга зохион байгуулах тодорхой журам байна.

Объектив тал нь сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг санаатайгаар буруу гаргах, сонгогчдоос саналаа нууцаар чөлөөтэй гаргах журмыг зөрчсөн бодитой үйл ажиллагаа үйлдэл байна.

Субъект нь сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, санал хураалтын дүнг буруу гаргасан гэм буруутай сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, бусад албан тушаалтан хэрэг хариуцах чадвартай, насанд хүрсэн хэн ч байж болно.

Субъектив тал нь санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах гэсэн зорилготой, шууд санаатай хэлбэртэй байна.

Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарласан Монгол Улсын дээд шүүхээс 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолд:

Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасан “бусад албан тушаалтан” гэдэгт нэр дэвшигчдийн болон сонгогчдын нэрсийн жагсаалт, нэр дэвшигчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэрэг сонгуулийн баримт бичгийг олгох үндэслэл болж буй анхан шатны бүртгэл, баримт бичиг, иргэний үнэмлэхийг энэ зүйл, заалтад дурьдсан зорилгоор хуурамчаар үйлдсэн албан тушаалтныг хамааруулж ойлгоно. Мөн зүйл, хэсэгт заасан “саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн” үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар тогтоосон саналаа чөлөөтэй илэрхийлэх журмыг зөрчсөн, сонгуулийн хэсэгт саналаа тэмдэглэх, тасалгаа, хаалтгүй байх, саналаа тэмдэглэхэд нь элдэв саад үүсгэх, тухайн сонгогчоос өөр гадны хүнийг дэргэд нь байлгах, саналаа хэрхэн өгч байгаа байдалд нь шууд хяналт тавих, саналын хайрцгийг бүтүүмжлэхгүй байх, саналын хуудсанд тэмдэглэл хийж чадахгүй сонгогчийн саналыг итгэмжлэгдээгүй хүнээр тэмдэглүүлэх, тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, тэмдэггүй саналын хуудсаар санал өгүүлэх зэрэг хэлбэрээр илэрч болно.

ЭХ-ийн 131 дүгээр зүйлийн иш татсан УИХ-ын сонгуулийн тухай 2011 оны хууль хүчингүй болж 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сонгуулийн тухай хууль шинээр батлагдсан. Иймээс ЭХ-ийн 131 дүгээр зүйлийг хэрэглэх асуудал тодорхойгүй байна.

Сонгуулийн хуулиар зөрчил гэж тогтоосон үйлдэл, эс үйлдэхүй нь ЭХ-ийн зүйл ангитай давхацвал Сонгуулийн хуульд заасан зөрчлийн хэмжээнд шалгах ба энэ талаар холбогдох хуулийн байгууллагуудад өгч байгаа чиглэл удирдамжийн дагуу хэргийг шалгана.

Доромжлох гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүн

Доромжлох гэмт хэрэг гэдэг нь хүний нэр төр, алдар хүндэд халдсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 110-р зүйлд хуульчлан тодорхойлж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Доромжлол, түүний шинж байдал.

Доромжлол нь хохирогчид өөртөө гутрах сэтгэл төрүүлдэг хортой уршигтай гэмт хэрэг. Зарим тохиолдолд энэ гэмт хэргийн улмаас хүмүүс хохирогчоос зайлсхийх, уулзахгүй байх, дайжих зэрэг үр дагавар бий болгож болно. Доромжилсон үг хэллэгийн жирийн, зүй ёсны буюу анхдагч утгыг тухайн үгийн далд утгатай харьцуулан авч үзэх хэрэгтэй.

Тухайн үг нь доромжилсон утга агуулгагүй байх мэт боловч бусад баримттай уялдуулан үзвэл цаад далд утга буюу доромжилсон утга гарч ирж болно. Доромжлох гэмт хэрэг нь гүтгэх гэмт хэргээс ялгагдах тал нь ямар нэгэн ор үндэсгүй зүйлийг гаргаж хэлдэггүй, харин тухайн хүний зан төлөв, хувийн байдалд эсрэг, сөрөг дүгнэлт өгч байдаг.

Доромжилсон үг нь хохирогчид шууд хандсан, түүнд хамааралтай байх ёстой. Хохирогчийн нэрийг дурьдаагүй ч доромжлогдож байгаа этгээд хохирогч мөн гэдгийг тогтоох боломжтой бол гэм буруутай этгээд хариуцлага хүлээнэ. Гэм буруутай этгээдийн зүгээс тодорхой нэг этгээдийг доромжилсон боловч энэ нь нэр нэгтэй бусад этгээдийн хувьд доромжлол болж болно.

Объект: Бусад хүний нэр төр, алдар хүнд байна.

Объектив тал: Хүний нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө доромжилсон үйлдэл байна. Хуульд заасан хор уршиг шаардахгүй, шалтгаант холбоогүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу доромжилсон үеэс гэмт хэрэг төгсөнө,

Нэр төр гэж тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмжийг хэлнэ. Хуульд заасан “олон нийтийн өмнө” гэдгийг зөвхөн олон нийтийн газар гэдэг утгаар нь ойлгох нь буруу бөгөөд хуулийн агуулга бол олон нийтийн газар байршил гэсэн санааг агуулаагүй бөгөөд хүний тодорхой тоо хэмжээний агуулга гол чухал ба газар байршил нь хаана ч байж болно. Олон нийт гэдэг нь цөөн хүн биш хүний тооны хувьд харьцангуй үлэмж их, бөөн, олон хүн байна гэсэн үг юм.

Доромжлох хэлбэр нь:

- Үг хэлээр/ олон нийтийн дунд чанга ярих, илтгэл лекц, тавих мэдээлэл хийх/

- Бичгээр нэр төр, алдар хүндийг доромжлох /нийтэд зориулсан самбар, зарлал, реклам зэрэг хэлбэртэй байж болно./

Үйлдлээр гэсэн хэлбэрээр доромжлох. /Олон нийтийн өмнө бусдыг цохих зангах, нулимаж, хамар, хацар, үс зулгаах зэрэг хэлбэртэй ба зодох гэмт хэргээс ялгаатай нь хүний бие махбод, эд эрхтэнд нь ямар нэгэн гэмтэл, өвдөлт үүсгэдэггүйгээрээ ялгагдана./

Доромжлох гэдэг нь хууль зүйн хувьд нийтээрээ тогтсон, ёс суртахуун, зан үйлийн хэм хэмжээг үл хүндэтгэн, хүнийг доог тохуу болгох, зүй зохисгүй байдлаар нэрлэж дуудах, үнэлж бичих, үнэн бодит байдлыг гуйвуулан үгүйсгэж буй явдал юм.

Энэ гэмт хэргийн санаа зорилго нь: Гэм буруугийн санаатай хэлбэрээр буюу тухайн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, ингэхийг хүсэж үйлдэгддэг. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах, өшөөгөө авах, уур хорслоо тайлах гэх мэт сэдэлттэй байж болох ч зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Доромжлох гэмт хэргийн зүйлчлэлийн зарим асуудал

Албан түшаалтан эрх мэдэл, албан тушаалын давуу байдлаа ашиглан бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжилбол Эрүүгийн хуулийн 111-р зүйлээр зүйлчлэхээс гадна Эрүүгийн хуулийн 263, 264, 265, 266-р зүйлийн аль тохирохоор давхар зүйлчилнэ.

Тухайн хүний ажил төрөл, үйл ажиллагаанд бодитой илэрдэг хамт олонд илэрхий байдаг доголдол, дутагдал, шүүмжлэлийг шударгаар хэлж шүүмжилж ярихдаа зүй бус үг хэллэг хэрэглэсэн тохиолдолд доромжлох гэмт хэрэг болохгүй.

Доромжлох гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 110-р зүйл/, Гүтгэх гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 111-р зүйл/ ялган зүйлчлэх нь:

Гүтгэх, доромжлох гэсэн гэмт хэргүүд нь Эрүүгийн хуулийн 16-р бүлэг "Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг" гэсэн бүлэгт хуульчлагдсан бөгөөд төрлийн, шууд объектоороо, субъект нь нийтлэг буюу 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байдгаараа ч төстэй байна. Эдгээр гэмт хэргүүдийн ялгааг дараах байдлаар тайлбарлаж болно.

А. Объектив талын шинжээрээ ялгаатай

Эдгээр гэмт хэргүүд нь бусдын нэр төр, алдар хүндэд халдсан байдгаараа, хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээрээ төстэй боловч доромжлох гэмт хэргийн хувьд олон нийтийн өмнө доромжилсон үйлдэл, эс үйлдэхүй байх ба харин гүтгэх гэмт хэргийн тухайд илт худал гүжирдлэг бусдад тараасан үйлдэл байдгаараа ялгаатай,

Б. Субъектив талын шинжээрээ ялгаатай

Гэм буруугийн шууд санаагаар үйлдэгддэгээрээ төстэй боловч гүтгэх гэмт хэрэг нь хүний нэр төр, алдар хүндийг гутаах гэсэн тусгай зорилго агуулсан байдгаараа доромжлох гэмт хэргээс ялгаатай.

Мөн доромжлох үйлдэл нь хохирогчийн ёс суртахуун, зан төлөвийн талаар ор үндэсгүй худал зүйлийг хөндөн тавьж байгаа асуудал биш харин хохирогчид хэтрүүлэг бүхий сөрөг дүгнэлт өгч басамжилж байгаагаараа гүтгэх гэмт хэргээс ялгагдана.

Гүтгэх гэмт хэргийн ойлголт, бүрэлдэхүүний шинж

Гүтгэх гэмт хэрэг гэдэг нь хүний нэр төр, алдар хүндэд гэм буруугийн шууд санаагаар илт худал гүжирдлэг тарааж халдсан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 111-р зүйлд хуульчлан тодорхойлж эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гүтгэлэг бол ор үндэсгүй худал мэдээлэл юм. Гүтгэлэг бүхий мэдээлэл нь агуулын хувьд бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан шинжтэй эсхүл гутаагүй шинжтэй байдаг.

Зорилгын хувьд шууд санаатай тараах / мэдсээр байж хүсэж үйлдэх /, өөр бусад зорилгоор / дуулиан шуугиантай мэдээлэл тавьж борлуултын орлогоо нэмэгдүүлэх, уншигчдыг татах / байж болно. Эрүүгийн эрх зүйн хувьд бусдын нэр төр алдар хүндийг гутаах зорилгоор санаатайгаар тараасан гүтгэлэг нь гэмт хэрэгт тооцохоор заасан тул хамгийн гол нь санаа зорилгыг нь анхаарах ёстой. Хэрвээ гутаах шууд санаа зорилго байхгүй нь тогтоогдвол иргэний болон захиргааны хариуцлага хүлгээлгэнэ.

Илт худал гүжирдлэг нь хохирогчийг гутаасан шинжтэй байхаас гадна хохирогч өөрт нь шууд чиглэсэн, бусад этгээдийн хувьд мэдээлэл хүлээн авагч гэдэг утгаар нь "итгүүлэх, төөрөгдүүлэх" гэж хандсан байдаг.¹¹

Гүтгэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг авч үзвэл:

Объект: Нэр төр, алдар хүнд, хүний халдашгүй байх эрх байна. Хүний эрхийн

¹¹Хүний эрх, эрх чөлөө алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг. /сургалтын гарын авлага/ УБ., 2007. 23 дахь тал

түгээмэл түнхаглалд "...хүний ёсноос гадуур буюу нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэх ёсгүй", Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.13-т "Хэнд боловч... хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй", 16.17-д "Хүний... нэр төр, алдар хүнд...-ийг хуулиар тогтоон хамгаална" хэмээсэн байна.

Объектив тал: Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан үйлдэл, эс үйлдэхүй байна. Хуульд заасан хор уршиг шаардахгүй, шалтгаант холбоогүй хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу худал гүжирдлэг тараасан үеэс гэмт хэрэг төгсөнө.

Хүний нэр төр, алдар хүндийг гутаах гэдэг нь тухайн нийгэм болон мэргэжлийн тухайн салбартаа ба бусдад үнэлэгдэх зүй ёсны бодит үнэлгээг бууруулах, унагах доройтуулан гажуудуулахыг хэлнэ.

Гүтгэлэгийн үр дүнд олон нийт болон тодорхой нийгмийн нэг хэсэг, бүлэг, ойр дотны хүмүүс нь хохирогчийг үл хүндлэх, доог тохуу хийх, хардах, сэжиглэх, хохирогчоос зайлсхийх, түүнд итгэх илтгэл буурах зэрэг үр дагавар бий болдог.

Гүтгэх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нэг шинжийг олон нийтэд тараасан байхыг заасан байдаг. Олон нийтэд тараах үйлдэл нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр, олон нийтийн өмнө лекц, мэдээлэл, яриа хийх зэрэг олон хэлбэртэй байна. Илт худал гүжир гүтгэлэгийг аливаа хэлбэрээр тараасан үеэс энэ гэмт хэргийг төгссөнд тооцно.

Эрүүгийн хуульд хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй гэж заасан. Иймд тухайн мэдээлэл нь гүтгэлэг үү эсвэл үзэл бодол итгэл, үнэмшил үү гэдгийг ялгаж үзэх хэрэгтэй.

Дээрх гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр буюу тухайн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлаж, ингэхийг хүсэж үйлдэгддэг. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилго нь заавал байх шинж болно.

Доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хүндрүүлж үзэх буюу хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчилсан.

Доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд шийтгүүлсэн этгээд гэдэгт доромжлох, гүтгэх гэмт хэрэгт ял шийтгүүлсний дараа Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2, 78.3-т заасан ялгүй болох хугацаа өнгөрөөгүй, эсхүл ялгүйд тооцогдоогүй байхад гүтгэх гэмт хэргийг шинээр үйлдсэнийг ойлгоно. Харин Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлийн 78.2-т заасан ялгүй болох хугацаа өнгөрсөн, мөн зүйлийн 78.3-т заасан үндэслэлээр ялгүйд тооцогдсоны дараа доромжлох, гүтгэх гэмт хэргийг шинээр үйлдсэн бол урьд ял шийтгүүлсэнд тооцохгүй.

Гүтгэх гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүн: (Эрүүгийн хуулийн 111.3)

Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хүндэвтэр гэмт хэрэг, материаллаг бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилжээ.

Гүтгэх гэмт хэргийг иргэний эрх зүйн төстэй зөрчлөөс ялгах нь:

Гүтгэх гэмт хэрэг, иргэний эрх зүйн зөрчил нь хүний хуулиар хамгаалагдсан нэр төр, алдар хүндийн эрхэд халдаж гэм хор, хохирол учруулдаг, хүний нэр төр, алдар хүндийг гутаах хууль бус үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ, субъектүүд нь эрх зүйн хариуцлага хүлээх чадвартай байна, гүтгэх гэмт хэргийн субъект болон иргэний эрх зүйн зөрчил гаргагч буюу хариуцагчид хууль зүйн хариуцлага хүлээлгэнэ гэсэн төстэй бөгөөд ялгаатай талыг дараах байдлаар тайлбарлаж болох юм.

А. Гүтгэх гэмт хэрэг нь нийгмийн хор аюулын шинжээрээ түүнтэй төстэй иргэний эрх зүйн зөрчлөөс үлэмж их байдаг.

Б. Гүтгэх гэмт хэргийн халдпагын зүйл нь нэр төр, алдар хүнд байдаг бол иргэний эрх зүйн зөрчлийн хувьд эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх байна.

В. Гэмт хэргийн тухайд гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгддэг бол иргэний эрх зүйн зөрчил гэм буруугийн санаатай хэлбэр шаардахгүй.

Г. Гүтгэх гэмт хэрэг нь хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилготой байдаг бол

иргэний эрх зүйн зөрчил нь тодорхой зорилго, сэдэлт шаардахгүй.

Д. Гүтгэх гэмт хэргийн субъект 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай этгээд байх ба ял оногдуулж, ял шийтгэгдсэн байдал бий болно. Харин иргэний эрх зүйн зөрчлийн субъект нь гэм хор учруулсан хувь хүн төдийгүй түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон хуулийн этгээд, төр байж болдог ба ял шийтгэгдсэн байдал бий болдоггүй.

Гүтгэх гэмт хэргийг захиргааны эрх зүйн төстэй зөрчлөөс ялгах нь:

Гүтгэх гэмт хэргийн объектив талын үндсэн шинж болох хохирлын хэмжээ нь тухайн үед мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага буюу өнөөгийн байдлаар 192 000 төгрөгөөс доош хэмжээний хохиролтой бол гүтгэх гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч ялимгүй учир нийгэмд аюулгүй үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй гэсэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг үндэслэн шийдвэрлэх боломжтой.

Энэ төрлийн гэмт хэргийг мөрдөх ажиллагааны онцлог

Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа нь бусад гэмт хэргийг шалгадаг нийтлэг ажиллагааг явуулахаас гадна зарим онцлог шинжүүд байдаг.

Сонгууль зохион байгуулахтай холбоотой дээрх гэмт хэргийг цагдаагийн байгууллагаас шалгах эрх зүйн үндэс нь дараах байдлаар тодорхойлогдоно.

Сонгуулийн тухай хуулийн 165.3-д Сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Түүнчлэн сонгуулийн хуульд заасан зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх нь тухайн асуудлыг эрүүгийн байцаан шийтгэх журмаар шалгахад саад болохгүй.

Харин сонгуулийн нэр дэвшигчийн тухайд бол гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчид холбогдуулан сонгуулийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр зарим эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй талаар тусгайлан заажээ.

Тодруулбал:

- эрүүгийн хариуцлагад татах буюу эрүүгийн хэрэг үүсгэх;
- баривчлах;
- албадан саатуулах;
- цагдан хорих;
- орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх зэрэг болно.

Кейс-8. УИХ-ын 2012 оны сонгуулийн үеэр иргэдээс болон Сонгуулийн ерөнхий хорооноос цагдаагийн байгууллагад гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэгт хийсэн судалгаа хийхэд: Сонгуулийн хэсгийн байрнаас эд зүйлс алдагдах, сонгуулийн хэсгийн байрны ойролцоо нэр дэвшигчийг доромжилсон агуулгатай анонс, самбар байрлуулах, сонгуулийн хэсгийн гишүүнийг аль нэг нэр дэвшигчид илүү санал өгүүлэх талаар заналхийлэх, сонгуулийн хэсгийн байранд танхайрах, сонгуулийн саналын хуудастай хайрцаг, санал тоолох машиныг авч зугтах, хууль бус жагсаал, цуглаан зохион байгуулах, сонгуулийн хэсгийн гишүүдийн биед хүч хэрэглэх, гэмтээх, зодох, сонгууль явуулах, санал авах хугацаа хэтэрсэн байхад иргэдээс санал авсан, саналын хуудас тоолох автомат машин саналыг худлаа тоолсон, нэр дэвшигчийг гүтгэх, доромжилх, нэр дэвшигч мөнгө тараасан гэх зэрэг гомдол, мэдээлэл цагдаагийн байгууллагад ихэвчлэн ирсэн байна.

Гэмт хэрэг бүр өөрийн онцлогтой байдаг бөгөөд тэр бүрт тохирсон мөрдөн байцаах аргачлалыг боловсруулах нь боломжгүй юм.

Иймээс гэмт хэргүүдийг төрөл, нийтлэг шинжээр нь бүлэглэн тодорхой төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн байцаах аргачлал боловсруулна. Гэхдээ эдгээр зөвлөмж нь хөдөлбөргүй тогтоосон журам биш харин сонгон хэрэглэж болох хувилбар гэдгийг мартаж болохгүй юм.

Сонгуультай холбоотой гардаг гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад анхаарах нийтлэг асуудлуудыг дараах байдлаар тодорхойлж, зөвлөмжид орууллаа.

1. Нэр дэвшигчтэй холбоотой хэрэгт хийгдэх ажиллагааны онцлог

Сонгуульд нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт татаж шалгах үндэслэл доорх тохиолдолд үүсч болно.

Үүнд, сонгууль зохион байгуулж явуулах хугацаанд нэр дэвшигчийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах аргаар хуульчилсан.

Гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт нотлох баримттайгаар баривчилсан тохиолдол ЦБҮАЖ-ын 309-д заасан зарим заалтыг баримтална.

Нэр дэвшигчийг эрүүгийн хариуцлагад татаж, сэжигтнээр тооцох үндэслэлийг тухайн цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга хэрэг материалтай биечлэн танилцаж, харьяалах прокурор болон цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулна. Түүнчлэн нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах болсон үндэслэлийг тодорхой тусгасан танилцуулгыг цагдаагийн төв байгууллагаас Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа цагдаагийн байгууллага нь Цагдаагийн төв байгууллага болон Сонгуулийн ерөнхий хороог холбогдох хуулийн хүрээнд мэдээллээр хангаж ажиллана.

Цагдаагийн төв байгууллагын Гэмт хэрэгтэй тэмцэх албанаас Эрүүгийн байцаан шийтгэх хууль бусад хууль тогтоомж, эрх зүйн бусад актын хүрээнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж байгаа цагдаагийн байгууллагад удирдлага зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэгт шалгах нэр дэвшигчийн талаар мэдээлэл бүхий танилцуулгыг сонгуулийн тойргийн хороонд хүргүүлж, уг нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах хүсэлтийг мэдэгдэж албан ёсны хариуг бичгээр авна. Нэр дэвшигчийг эрүүгийн хэрэгт шалгах зөвшөөрөл хүсэхтэй холбоотойгоор энэ журмаар зохицуулагдаагүй тохиолдол гарвал сонгуулийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг баримталж ажиллана.

2. Сонгуультай холбогдох гэмт хэргийг "халуун мөрөөр нь" бүртгэх, мөрдөн байцаах онцлог

Сонгуультай холбоотой гэмт хэрэг нь цаг үеийн шинжтэй байдгаараа онцлогтой. Гэмт хэргийн ул мөр, гэрч, нотлох баримтыг цаг алдалгүй олж тогтоох нь тухайн төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтэнд чухал. Боломжит богино хугацаанд гэмт хэргийн шинж тэмдэг илрүүлсэн буюу түүний тухай мэдээлэл авснаас хойш 24 цагийн дотор (зарим онцгой, төвөгтэй тохиолдолд ЭБШХ-ийн 171-р зүйлд заасан хугацааны дотор сунгаж болно) шийдвэрлэсэн байхыг өгүүлнэ. Ийм хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт өвөрмөц нөхцөлд явагдана.

Хойшлуулшгүй ажиллагаа шаардсан нөхцөлт байдал гэнэт бий болох, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд цаг хугацаа хомсдох, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах процесс эрчимтэй байх, ерөнхий байдал болон мөрдөн байцаалтын нөхцөлт байдлын хурдан өөрчлөлт, шаардлагатай мэдээлэл дутмаг байх, шинэ баримтыг хойшлуулшгүй ашиглах амин чухал шаардлага тавигдах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад сөргөөр нөлөөлөх, мөр, гэмт хэргийн байдлыг нуух эдгээр

нөхцлүүд нь сонгуультай холбоотой гэмт хэрэгт зохион байгуулалт, "халуун мөрөөр нь" хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах үндсэн шаардлагыг тодорхойлно.

а/ Мөрдөн байцаах шуурхай хэсэг буюу ажлын хэсэг хэрэг болсон газарт яаралтай хурдан очих, эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах шийдвэрийг шуурхай гаргах;

б/ Шаардлагатай хүч, хэрэгслийг нэн даруй татан оролцуулах;

в/ Ажиллагааны үлгэрчилсэн програмчлалыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт ажиллагаа тус бүртэй хослуулах; /мөрдөн байцаах ажиллагаа, шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээг зөв сонгох, явуулах дарааллыг баримтлах/

г/ Богино хугацаанд нотлох баримтыг бүрэн цуглуулах, бэхжүүлэх техник хэрэгслийг өргөнөөр ашиглах, мэдээллийг цагдаагийн байгууллагад шуурхай хүргэх, мэдээлэл агуулагчийг яаралтай шинжлэхэд мэргэжилтэн, экспертийн туслалцааг бүх талаар ашиглах.

Энэ шаардлагын хэрэгжилт нь цагдаагийн бүх салбарын хамтын ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, цаг тухайд нь зохих арга хэмжээ авахад чиглэсэн цагдаагийн байгууллагын хүч, хэрэгслийн төвлөрсөн удирдлагаар хангагдана.

Төрийн албаны болон сонгуулийн тухай хууль тогтоомжид "...төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагч аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд оролцох, сонгуулийн сурталчилгаа бие даан явуулахыг хориглоно" гэж заасны дагуу аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн үйл ажиллагааг дэмжих, эсэргүүцэх зэрэг идэвхтэй хэлбэрээр оролцохгүй байж асуудалд хүлээцтэй, төрийн албан хаагчийн байр сууринаас хандаж, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах үүрэгтэй.

ДОЛОО. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

7.1. Сонгуулийн автоматжуулсан систем түүний аюулгүй байдлыг хангах

Монгол Улс түүхэндээ анх удаа 2012 оны Улсын Их Хурал, 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудад санал тоологын автомат машин ашигласнаас гадна биеийн давхцахгүй өгөгдөл болох хурууны хээгээр сонгогчийг таньж, бүртгэснээрээ онцлогтой юм. Автомат сонгуулийн системийг тухайн үед 3750 орчим компьютерт холбож, аймаг, нийслэлийн нийт 1896 хэсгийн хороонд автоматаар сонгогчдын бүртгэж, сонгуулийн ирцийн мэдээг 2000-аас дээш км алслагдсан газруудаас утасны сүлжээ ашиглан хүлээн авч цаг алдалгүй хянаж байсан байна.¹²

Сонгуулийн автоматжуулсан систем нь сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, улсын хэмжээнд сонгогчдын нэгдсэн бүртгэл үүсгэх, хурууны хээгээр сонгогчийн мэдээллийг түргэн шуурхай хайж олох, бүртгэл хийх, сонгуулийн үеэр гардаг зөрчил маргааныг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, сонгогчдын ирц бүртгэх, тоолох, сонгуулийн дүн гаргах зэрэг сонгуулийн үе шатны ажиллагааг боловсронгуй болгох, хөдөлмөр хөнгөвчилж, хүний ажиллагаанаас гарч болох алдааг багасгах, сонгуультай холбоотой тайлан, статистикийг үнэн бодитоор гаргах, бүх төрлийн сонгуульд ашиглаж болохуйц, нэгдсэн нэг системтэй, сонгогчдын сонгуульд оролцсон түүх бий болох, сонгуулийн явцыг цаг тухайд нь мэдээлэх, мэдээллийн аюулгүй орчныг үүсгэх, цаг хугацаа хүн хүч хэмнэх, сонгогчийн ирцийг мэдээг утасны сүлжээ ашиглан дамжуулах, хэрэглэхэд хялбархан програм зэрэг ашиг тус болон олон давуу талтай юм.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд түүнийг сонгуульд бэлтгэж, түүнийг хуулийн дагуу зохион байгуулахад ашиглах зориулалттай мэдээллийн сан бүрдүүлж, сонгогчийн хувийн мэдээлэлтэй тулган нягтлах, сонгогчдын саналыг авах, авсан саналыг тоолох, сонгуулийн дүнг нэгтгэн хадгалах, дамжуулах, баримтжуулах ажиллагааг автоматжуулах үүрэг бүхий цахим мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамж, тэдгээрийг ажиллуулах хүний нөөц, санхүүгийн эх үүсвэрийн харилцан уялдаа бүхий цогцыг;

“автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл” гэж мэдээллийг оруулах, боловсруулах, нэгтгэх, хадгалах, хайх болон дамжуулах зориулалттай харилцан уялдаатай техник хэрэгсэл, програм хангамжийн нэгдлийг гэж заажээ.

7.2. Сонгуулийн автоматжуулсан системийн бүтцийн тухай ойлголт

Сонгуулийн автоматжуулсан систем нь бүртгэлийн хэсэг буюу хурууны хээ таних машин, бүртгэлийн хуудас хэвлэх принтер, мэдээлийн бааз бүхий толгой компьютер түүнтэй холбогдсон бусад компьютер, санал тоолох машин, сүлжээ гэсэн 3 хэсэгт хувааж үзэж болно.

Автоматжуулсан системийн бүрэлдэхүүн хэсгүүд:

а/ Сонгогчийн удирдлагын програм: Сонгогчийн удирдлагын програм нь сонгуулийн ирцийн бүртгэлийг нэгдсэн удирдлагад оруулж, сонгуулийн явцын мэдээг олон нийтэд онлайн орчинд хүргэнэ. Сонгогчдийн нэрийн жагсаалтын нэгдсэн сан бүрдүүлж, түүнийг удирдах, хэсгийн хороо бүрийн сонгогчийн жагсаалтыг үүсгэж, нэгжийн сонгогчийн ирц бүртгэлийн програмд экспортлоно. Сонгуулийн ирцийн нэгдсэн тайланг гаргана.

Тойрог, хэсэг, хэсгийн хорооны хаяг, хэсгийн хорооны бүртгэгч зэрэг сонгуультай холбогдолтой нэгдсэн удирдлага бүхий тохиргоо, хуулийн дагуу давхардалгүй боловсруулагдсан сонгогчийн нэрийн жагсаалт бүхий програм юм.

¹²2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн тойм

Кейс-8. *Өвөрхангай аймгийн хэмжээнд хуулийн дагуу өглөөний 07.00 цагаас 106 хэсэг дээр санал авах ажиллагаа эхэлжээ. Харин өглөөгүүр тус аймгийн Баруунбаян-Улаан сумын Таацын багт хурууны хээ уншиж бүртгэл гаргадаг принтер нь гацаж шатсан байна. Тиймээс цаг алдахгүйн тулд аймгийн ИБМА-наас хурууны хээ таних машиныг авч сум руу хүлээлгэж өгчээ. Энэ хугацаанд хурууны хээ авах ажиллагааг гар ажиллагаанд шилжүүлэн ажилласан аж.*

б/ Сонгогчийн ирц бүртгэлийн програм: Сонгогчийн ирц бүртгэлийн программ бүхий систем нь санал авах байранд байрлаж, сонгуулийн өдөр сонгогчийгиргэний бүртгэлийн мэдээллийн улсын санд биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн бүртгэлтэй тулгаж, тухайн хэсгийн хорооны сонгогчдыг ирцийн мэдээг автоматаар сонгогчийн төв удирдлагын систем рүү илгээнэ. Уг системийн чухал функциональ ажиллагаанууд гэвэл сонгогчийн давхцахгүй өгөгдлийг сонгогчийн баазтай тулгаж хянах, сонгогчийн хурууны хээ танигдахгүй тохиолдолд сонгогчийн регистрын дугаар, цахим үнэмлэхээр давхардалгүй таних, танисан сонгогчид тасалбар хэвлэж ирцийг бүртгэх, санал өгсөн болон нэрийн жагсаалтад байхгүй сонгогчийн мэдээлж санал өгүүлэхгүй байх боломжийг хангах, ирц бүртгэлийн бүх шаардлагатай тайланг гаргах, сонгуулийн явцыг нээлттэй байлгах үүднээс бүртгэсэн сонгогч бүрийн зураг болон хувийн мэдээллийг тухайн хэсгийн хороон дээр дэлгэцээр харуулах боломжтой.

Сонгуулийн ирц бүртгэлд хууль зөрчсөн үйлдэл гарахаас урьдчилан сэргийлж, хэрэглэгчийн түвшинг хязгаарласнаас гадна програм хангамжийн хэрэглэгчийн хийсэн үйлдлүүд түүх болж хадгалагддаг.

Сонгуулийн автоматжуулсан системийн зохион байгуулалтын бүтэц нь сонгуулийн хороодын тогтолцоонд суурилсан байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн бүрэлдэхүүнд:

- Сонгуулийн ерөнхий хорооны /түүний дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн/ автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл;
- Сонгуулийн тойрог, хэсгийн хорооны автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл багтана.

Автоматжуулах хэрэгслийн иж бүрдэлд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, програм хангамж нь төрийн өмч юм.

Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн санд дараах мэдээлэл байна.

- Сонгуулийн эрх бүхий иргэдийн бүртгэлийн нэгдсэн сан, сонгуулийн тойрог, хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалт, түүнтэй холбогдох бусад мэдээлэл;
- Сонгуульд нэр дэвшигчид, тэдгээртэй холбогдох бусад мэдээлэл;
- Сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаарх мэдээлэл;
- Санал хураалтын явц болон дүнгийн талаарх мэдээлэл;
- Сонгуулийн хороодын үйл ажиллагааны талаарх болон хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн санд цаасан дээр үйлдсэн болон цахим хэлбэрээр үйлдсэн бүх баримт бичгийг оруулна.

Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээллийн санд цаасан дээр үйлдсэн баримт бичгийг оруулсан бол түүнийг цахим хэвлэх төхөөрөмжөөр хэвлэн гаргаж зохих албан тушаалтан гарын үсэг зурж хувийг албан хэрэгт хадгалах бөгөөд мэдээллийн санд цахим хэлбэрээр баримт бичиг үйлдэж цахим гарын үсэг зурсанболэнэ тухай тусгай бүртгэл хөтөлнө.

Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглан бэлтгэсэн цахим баримт бичиг нь зохих албан тушаалтны цахим гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Интернет хүний амьдралын салшгүй хэрэглээ болсон өнөө үед төрийн болон санхүүгийн төрөл бүрийн бичиг баримт гэрээ хэлцлийг цахимаар илгээх, хүлээн авах зэрэг олон төрлийн хэргээ үүссэн. Эдгээр хэрэгцээг хангахад цахим орчинд холбогдсон

хүмүүсийн итгэлцлийг бий болгох, мэдээллийг аюулгүй дамжуулах, нууцлан хамгаалах, бүрэн бүтэн байдлыг хангах, цахим орчинд иргэдийг таних, баримт бичгийн эзэн эх сурвалжийг тогтоох хэрэгцээ шаардлага тулгардаг. Эдгээр асуудлыг цахим, тоон гарын үсгээр шийдвэрлэж чаддаг боллоо.

Цахим хэлбэрээр үйлдсэн баримт бичиг нь зөвхөн цахим гарын үсгээр баталгаажна.

Цахим баримт бичиг гэдэг нь компьютер, компьютерийн програм болон ижил төрлийн бусад хэрэгслийг ашиглан үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах боломжтой цахим өгөгдөл байдаг бол цахим гарын үсэг нь цахим баримтад гарын үсэг зурсан этгээдийг тодорхойлох зорилготой цахим баримт бичигт хавсаргасан буюу нэгтгэсэн үг, үсэг, тоо, тэмдэг, дүрсийг агуулсан цахим өгөгдөл байна.

Цахим гарын үсэг нь тоон гарын үсгээр илэрхийлэгдэж болно. Тоон гарын үсэг нь цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрлийг гэж ойлгоно.

“Цахим түлхүүр” гэж автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл, түүний аль нэг хэсгийг ашиглах, мэдээлэлд нэвтрэх, мэдээллийн санд байгаа тоон дүн, баримт бичигтэй харьцах боломжийг цахим түлхүүр эзэмшигчид олгох зорилгоор мэдээллийг нууцлан дүрс, тоон хэлбэрт оруулан үйлдсэн түлхүүрийг ойлгоно.

Сонгуулийн цахим баримт бичгийг дээд шатны сонгуулийн хороонд дамжуулахын өмнө уг баримт бичиг бүрийн цахим гарын үсгийг шалгаж, энэ тухай тэмдэглэл үйлдэнэ.

Дээд шатны сонгуулийн хороо хүлээн авсан цахим баримт бичгийн цахим гарын үсгийг шалгаж, энэ тухай тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлийг цахим төхөөрөмжөөр хэвлэн гаргаж, хүлээн авсан албан тушаалтан гарын үсэг зурж, тусгай бүртгэл хөтлөн албан хэрэгт хадгална.

Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй байдал

***Кейс-9.** Бүртгэлийн хэсэгт сонгогчийн хурууны хээг танихгүй байх, хэвлэх машин гацах, мэдээллийн баазад бүртгэлгүй хүмүүс байх тохиолдлууд гарсан. Бүртгэлийн системийн үр дүнд хүүхдийнхээ иргэний үнэмлэхээр санал өгөх гэсэн тохиолдлыг илрүүлсэн байна.*

Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй байдлыг Сонгуулийн ерөнхий хорооны үйл ажиллагаатай уялдуулан цагдаа, тагнуулын болон хяналт шалгалтын бусад байгууллага тус тусын чиг үүрэг, бүрэн эрхийнхээ хүрээнд ханган ажиллана.

Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй байдлыг хамгаалалтын техник-зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх, системийн ашиглалтын явцад хяналт тавих замаар хангана.

Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй байдлыг хамгаалалтын дараах үндсэн арга хэмжээгээр хэрэгжүүлнэ:

Үүнд:

- Сонгуулийн автоматжуулсан систем, түүний техник хэрэгсэл, програм хангамжийг зохих журмын дагуу гэрчилгээжүүлэх;
- Нийтийн хэрэглээний болон тусгай зориулалтаар ашиглах зөвшөөрөл, гэрчилгээ бүхий програм, техник хэрэгсэл, харилцаа холбооны суваг ашиглах;
- Сонгуулийн автоматжуулсан системд хууль бусаар нэвтрэх боломжийг бүрэн хаах;
- Мэдээллийн санд байгаа мэдээллийн бүрэн бүтэн байдал, үнэн зөв болохыг баталгаажуулах;
- Мэдээллийг мэдээлэл, харилцаа холбооны сүлжээгээр дамжуулах үед хамгаалах;
- Сонгууль зохион байгуулахад сонгуулийн автоматжуулсан системийн бэлэн байдлыг тусгайлан шалгах;
- Холбогдох журмаар баталсан ашиглалтын баримт бичгийг хэрэглэх;
- Автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийн хэвийн ажиллагаа, түүний бүрэн бүтэн

байдлыг хангах арга хэмжээ авах;

-Автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг ашиглах эрхийн гэрчилгээ бүхий ажилтныг бэлтгэх.

Сонгуулийн автоматжуулсан системийн аюулгүй байдлыг хангах үүргийг тухайн автоматжуулах ажиллагаанд оролцож мэдээлэл, харилцаа холбооны болон бусад төрлийн ажил, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцна.

Сонгуулийн автоматжуулсан системд ашиглах програм хангамж, техник хэрэгслийн ажиллагааг шалган туршиж баталгаажуулах ажлыг Мэдээллийн технологийн төв, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Тагнуулын ерөнхий газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг хариуцан гүйцэтгэж, гэрчилгээг олгоно.

7.3.Сонгуулийн автоматжуулсан системд мэдээлэл, харилцаа холбооны сүлжээг ашиглах

Сонгуулийн автоматжуулсан системийн мэдээлэл солилцох ажиллагааг явуулахад нийтийн хэрэглээний, салбарын болон бусад мэдээлэл, харилцаа холбооны сүлжээний нөөц сувгийг хууль тогтоомжийн дагуу ашиглана.

***Кейс-10.** Дундговь аймгийн сонгуулийн 47-р тойргийн хорооны санал авах хайрцаг задлах үед туршилтын кодоор онгойлгох байтал санал авах өдрийн онгойлгох кодоор хайрцагийг андуурч онгойлгосон нь технологийн даамал Т-ийн тайлбараар сейфнээс 2 дугуйтай бичиг гаргаад нэгийг нь задлаад дотор нь байсан кодоор машиныг асаасан, тэгээд уг кодоор буцаан унтраагаад дугуйтуйгаа хартал сонгуулийн өдөр хэрэглэнэ гэсэн бичиг байсан.*

Сонгуулийн автоматжуулсан системийг ашиглаж байгаа ажилтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүй, зөрчил илрүүлсэн тохиолдолд хяналтын хэсэг энэ тухай үндэслэл, нотолгоо бүхий тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулсны үндсэн дээр зохих шатны сонгуулийн хорооны даргад даруй танилцуулж, зөрчлийг арилгах саналаа тухайн сонгуулийн хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

Хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

НАЙМ. ЦАХИМ МЭДЭЭЛИЙН ХҮРЭЭНД ҮЙЛДЭГДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨН ШИНЖЛЭХҮЙН АРГА ҮНДЭС

Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг – Компьютерийн мэдээлэл, програм, түүний төхөөрөмжийг санаатай өөрчлөх, эвдэх, гэмтээх, ашиглах боломжгүй болгох, мэдээлэл сүлжээг сүйтгэх, компьютерийн мэдээллийг зөвшөөрөлгүй хуулбарлах, хууль бусад аргаар олж авах, компьютер, мэдээллийн хамгаалалттай сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай програм, техник хэрэгсэл бэлтгэх, нянтай програмзохион бүтээх, ашиглах, тараах зэрэг Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай, үйлдэл, эс үйлдэхүйн цогц бүрдлийг хэлнэ.¹³

Нийтлэг бүрэлдэхүүн:

Объект: Монгол Улсын Эрүүгийн хуулиас үзэхэд, компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийн нийтлэг объект нь мэдээллийг компьютерээр боловсруулах үед үүсэх нийгмийн харилцаа байна.

Халдлагын зүйл нь компьютерийн тодорхой мэдээлэл, компьютерийн тодорхой систем болон сүлжээний өгөгдлийн сан, түүний файлууд, түүнчлэн техник хангамжийн тусгай технологи, програм, компьютерийн мэдээллийг хамгаалах хэрэгсэл болон бусад зүйл байна. Мөнгө, бусад материаллаг үнэт зүйл эсвэл тооцоолон бодох техникийн аппарат, техникийн хэрэгсэл нь бусад гэмт хэргүүдийн халдлагын зүйл болдог энэ хэргийн шууд халдлагын зүйл болохгүй.

Компьютерийн мэдээлэл, програмыг өөрчилж, эвдэлж, сүйтгэсэн, компьютерийн мэдээллийг хууль бусаар олж авсан, компьютерийн мэдээллийн сүлжээнд хууль бусаар нэвтрэх тусгай хэрэгсэл бэлтгэсэн, борлуулсан, нянтай програм зохион бүтээж, ашиглаж, тараасны үр дүнд бусад гэмт хэрэг үйлдэгдсэн бол гэм буруутай этгээд эрүүгийн хуулийн бусад зүйлд зааснаар давхар хариуцлага хүлээх учиртай.

Үүнд дараах зүйлийг дурьдаж болно.

- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийг компьютерийн мэдээлэл ашиглан үйлдсэн бол /Эрүүгийн хуулийн 79, 80, 87, 88 дугаар зүйл/;
- Хүний эрх, эрх чөлөө, алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг /110, 111 дүгээр зүйл/;
- Иргэдийн улс төрийн, бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг /131, 135, 136, 140, 141, 144, 145, 148, 149, 150, 151, 152 дугаар зүйл зэрэг байж болно.

Иймд компьютерийн гэмт хэргүүдийг

- Компьютерийн гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг/
- Компьютер ашиглан үйлдсэн гэмт хэрэг гэж ангилж болохоор байна.

Компьютерийн гэмт хэрэг гэдэгт компьютерт хадгалагдаж буй мэдээлэл халдлагын зүйл нь болж буй Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай үйлдлийг ойлгоно.

Ийм мэдээллийг хууль бусаар ашигласны үр дагавар нь янз бүр байж болно.

Тухайлбал, оюуны өмчийн эрх зөрчигдөх, хувийн нууц задрах, эд хөрөнгийн хохирол учрах, байгууллагын ашиг сонирхол зөрчигдөх гэх мэт байж болно.

Тийм ч учраас энэ төрлийн гэмт хэргийг “Нийгмийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг” гэсэн наймдугаар хэсэгт оруулжээ.

Тэгэхээр эдгээр гэмт хэргийн төрлийн объект нь нийгмийн аюулгүй байдал болон нийгмийн дэг журам; шууд объект нь компьютерийн мэдээллийг зүй зохистой, аюулгүй ашиглахтай холбогдсон нийгмийн харилцаа байна.

Объектив тал: Гол төлөв материаллаг үр дагавартай байхаар хуульчлагдсан байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн нийгэмд аюултай үйлдэл хийгээд зогсохгүй нийгэмд

¹³ С.Жанцан /Sc.D/, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” УБ, 2004, 452 дахь тал

аюултай үр дагавар учирсан байх, энэ хоёр шинжийн хооронд шалтгаант холбоо байхыг заасан байна. Тэгэхдээ эдгээр гэмт хэргийг үйлдсэн хугацааг үр дагавар нь хэдийд бийболсоноос үл хамаарч, үйлдэл төгссөн цаг хугацаагаар тооцно. Нийгэмд аюултай ажиллагаа голчлон үйлдлийн хэлбэрээр илрэх байгаа бөгөөд зөвхөн Эрүүгийн хуулийн 227 дугаар зүйлийн зарим заалтад заасан гэмт хэрэг эс үйлдэхүйгээр хэрэгжиж болно. Гагцхүү нэг тохиолдолд гэмт хэрэг үйлдэх аргын тухай заалт хүндрүүлэх бүрэлдэхүүний заавал байх шинжээр /226 дугаар зүйлийн 2/ заагджээ.

Субъектив тал: Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн субъектив талыг хууль тогтоогч зарим тохиолдолд шууд тодорхойлон гаргаагүй боловч зүйлүүдийн утга агуулгаас үзвэл, эдгээр гэмт хэрэг зөвхөн санаатай хэлбэрээр үйлдэгдэхийг заасан байна.

Эрүүгийн хууль¹⁴-ийн 226, 229 дүгээр зүйлд заасан гэм хорыг зөвхөн санаатай учруулах талаар шууд заасан.

Эдгээр гэмт хэргийн сэдэлт нь зүйлчлэхэд чухал ач холбогдолгүй бөгөөд ял шийтгэл оногдуулах үед л харгалзан үзнэ. Шунахай, эсвэл танхайн сэдэлттэй байж болохын зэрэгцээ өс хонзон, атаа хорсол, хувийн бусад сэдэлттэй байж болно.

Субъект: Уг төрлийн гэмт хэргийн зарим бүрэлдэхүүн тусгай субъекттэй байж болно. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 226 дугаар зүйлийн 2-т зааснаар өөрийн албан тушаалын хувьд компьютер, компьютерийн систем, сүлжээг ашиглах, нэвтрэн орох эрхтэй хүн тусгай субъект болно.

Эрүүгийн хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу 16 насанд хүрсэн хүн уг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн хуулийн 226 дугаар зүйлийн 2, 227 дугаар зүйлийн 2-т заасан үйлдлийг урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг этгээдийн үйлдсэн гэмт хэрэг гэж тооцохын тулд Эрүүгийн хуулийн 36 дугаар зүйлийн 3-ыг авч үзэх шаардлагатай. нийтийн хэрэглээний сүлжээнд нян тараах зэрэг болно.

“Цахим гэмт хэрэгтэн”-ний хувийн шинж төрхийн асуудал нь цахим мэдээллийн Хүрээн дэх гэмт үйл ажиллагааны криминалистикийн шинжид хамаарах асуудалд онцгой байр эзэлдэг. Судалгаанд хамрагдсан мөрдөн байцаагчдын 41 хувь, Шүүгчийн 38 хувь нь цахим хүрээнд гэмт хэрэг үйлдэгдсэн гэмт хэрэгтний сэтгэл зүйтэй хамааралтай асуудлыг судлах нь зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

Ер нь цахим техник хэрэгсэл нь үнэхээр техникийн өндөр мэдлэг, арга, чадварыг шаардах учир жирийн хэн нэг хүн-гэмт этгээд түүнийг үйлдэх боломжгүй бөгөөд хэдий чинээ нарийвчлалтай техник хэрэгслийг гэмт үйл ажиллагаандаа ашиглана, төдий чинээ цахим хэрэгслийн өндөр мэдлэг, чадвар шаардах нь ойлгомжтой тул тухайн үйл ажиллагаанд хэрэглэсэн техник хэрэгслийг судлах замаар тухайн үйлдэл хийсэн хүн-ээнийг тогтоож болох чиглэл тодорхой болно.

Цахим гэмт хэрэгтний хувийн шинж төрх, түүний онцлог нь гэвэл цахим гэмт хэрэгтнүүд техникийн өндөр мэдлэг, чадвартай тэр шинжээрээ бусдаас эрс ялгагдаж байдаг гэж ихэнх судлаачид үздэг байна.

Энэ нь бас үгүйсгэж болохооргүй онцлог шинж мөн. Ийм учир цахим мэдээллийн Хүрээн дэх гэмт үйл ажиллагаа нь маш нарийн зохион байгууллалттай байдаг учир тухайн гэмт үйлдлийн зохион байгуулагч, гүйцэтгэгч ба хамтран оролцогчид нь бусдаасаа илүү гоц ялгарч байдаг онцлогтой тул нэн ялангуяа цахим гэмт үйл ажиллагааг бодитойгоор хэрэгжүүлэгч-гүйцэтгэгч нь цахим техник хэрэгсэл, цахим мэдээллийг бүтээх, дамжуулах өндөр арга, чадвар, мэдлэгтэй болох нь амьдралд нэгэнтээ нотлогдож байна.

Цахим гэмт хэргийн үйлдэлд нөлөөлж байгаа үндсэн /нэрд гарсан/ нөхцөл байдлуудыг дараах 4 бүлэгт хуваан үзэж болно.

¹⁴ МУ-ын Эрүүгийн хууль 2002 он, 25 дугаар бүлэг 226-229 дүгээр зүйл

Үүнд:

“Сүүлээр нь тогтоох” тохироо нөхцөлүүд. Энэ нь цахим хүрээнд үйлдэж байгаа гэмт хэргийн бодит ул мөр болдог бөгөөд нэг үгээр хэлбэл мэдээллийн системд халдсан “дээрмийн” үйлдэл нь заавал ул мөрөө үлдээдэг гэж үздэг.

Жишээлбэл, файлыг устгаж байгаа цахим вирусны нөлөөлөл, хэвлэгдсэн мэдээ зэрэг нь бодит ул мөр байдаг. Энэ тохирол-нөхцөл нь хамгийн түгээмэл зүйл боловч түүнийг бодитойгоор олж тогтоох гэдэг нь үлэмж нарийн төвөгтэй ажиллагаа байдаг.

Учир нь цахим гэмт хэрэг нь маш урт цаг хугацааг дамжин үйлдэгддэгээрээ онцлогтой гэдгийг дээрх бүлгүүдэд дурьдсан.

“Дохио” тохирол нөхцөл. Энэ нь хэн нэгэн хүн цахим гэмт хэргийг үйлдэхэд бэлтгэж байгаа буюу үйлдсэн болох талаарх гомдол, мэдээлэл хүлээн авч байгаа тохирол-нөхцөл тул туйлын харьцангуй ойлголт байдаг учраас дараах зүйлийг онцгой анхаарах шаардлагатай. Үүнд:

-тухайн гэмт хэргийг үйлдсэн буюу үйлдэхэд бэлтгэж байгаа бодит “факт” түүнд холбогдсон мэдээлэл,

-тухайн хүн тодруулбал гомдол-мэдээлэлд дурьдсан хүн түүнийг үйлдэхэд оролцсон бодит байдал,

-тухайн гомдол-мэдээллийн бодит онцлог зэргийг нэн урьдчилан судлан үзэх шаардлагатай. Ялангуяа тэрхүү “дохио” гэмт хэрэг үйлдэхээс өмнө буюу үйлдсэний дараа авсан гэдгийг зөв тогтоох нь онцгой ач тустай. Амьдрал дээр хуурамч “дохио” нь тухайлсан гэмт хэргийг биш харин огт өөр цахим гэмт хэргийг үйлдэх ажиллагааг нуун дарагдуулахад чиглэсэн эх сурвалж байж болох талтай. Учир нь тухайн гэмт этгээд гэмт хэргээ нуун далдлах арга-үйлдлийг “бусдын гараар” хэрэгжүүлэх замаар ул мөрөө устгадаг тул түүнийг шалгахад /тогтооход/ хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд-мөрдөн байцаагчийн цахим техникийн мэдлэг чадвар онцгой ач холбогдолтой.

Цахим гэмт хэргийг үйлдсэний дараа ирж байгаа “дохио” нь мөн чанарын хувьд дээр дурьдсан “Сүүлээр нь тогтоох” тохироо-нөхцөлүүдтэй туйлын адилхан байдаг учраас нэгэнт болж өнгөрсөн цахим гэмт үйлдлийг чухамхүү дурьдаж байгаа тохироо, нөхцөлийг бодитой тогтоох замаар илрүүлдэг бөгөөд нэн ялангуяа мөрдөн байцаалтын анхан шатны үйл ажиллагаа буюу онцлобол эрүүгийн эрэн сурвалжлах ажиллагаа явуулахад ач холбогдолтой байдаг.

“Гардах” тохироо нөхцөл. Энэ нь цахим гэмт хэрэгтэн үйлдэл дээрээ баригдаж байгаа тохироо нөхцөлийг томъёолж байгаа ойлголт юм. Үүнийг мөрдөн шалгах арга барил, ашиглах, техник-хэрэгсэл нь янз бүр байх нь тодорхой боловч хамгийн гол нь тухайн тохироо-нөхцөлийн бодит буюу үйлдэгдсэн гэх гэмт үйлдлийг илрүүлэхэд ач тустай үндсэн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн дүүрэн тогтоох шаардлагатай. Учир нь энэ тохироо нөхцөл нь гэмт хэргийг “халуун ул мөрөөр нь” илрүүлж байгаа ажиллагаа байдаг.

“Сэрэмжлэх” тохироо нөхцөл. Энэ нь цахим хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийг илрүүлэх эх сурвалжийг тохиолдолын байдлаар Тухайлбал, мэдээллийг боловсруулж байгаа өдөр тутмын үйл ажиллагааны явцад тодорхойлж буй тохирол-нөхцөл юм. Энэ нь янз бүрийн ажиллагаа байж болох талтай тул тэр бүрийг тоочин бичих боломжгүй. Энэ тохирол-нөхцөлийн үед явуулах гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагаа үйлдэгдсэн фактыг зөв тогтоохоос эхлэх ёстой.

Цаашилбал, тухайн гэмт этгээдийн гүйцэтгэсэн үйлдлийг нарийвчлан тодорхойлж нэн ялангуяа цахим мэдээллийн гэмт хэргийн онцлог шинжийг болж өгвөл нэг бүрчлэн тогтоох шаардлагатай юм. Ер нь “сэрэмжлэх” ажиллагаа нь ялангуяа түүний боловсруулалтын явцад олж авсан мэдээ, мэдээлэл нь эрэн сурвалжлах ажиллагааг зөв явуулах урьдчилсан нөхцөл болж байдаг. Ялангуяа дараах асуудлуудыг онцгой анхаарах шаардлагатай. Үүнд:

1. Цахим гэмт хэрэг үйлдэгдсэн үндсэн факт тэдгээрийн гол мөн чанар онцлогыг

хэсэгчилж, болж өгвөл нэг бүрчлэн тогтоох,

2. Цахим гэмт этгээдийн үйлдлийн арга, ялангуяа түүний ашиг сонирхол, сэдэлт, зорилгыг тогтоох,

3. Цахим гэмт хэргийн үйлдлийн аргыг нэг бүрчлэн, нарийвчлан тогтоох,

4. Тухайн гэмт хэрэгт хамтран оролцсон хүн бүрийн үйлдэл, үүрэг ролийг нарийвчлан тогтоох,

5. Цахим гэмт хэргийн улмаас учирсан хор хохиролыг тогтоох,

6. Цахим гэмт хэргийг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл, бусад хүчин зүйлсийг нэг бүрчлэн тогтоох зэрэг болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Эрүүгийн хууль 2002
2. Төрийн мэдээлэл сэтгүүл. 2016.01.22. №04 /913/
3. Ерөнхийлөгчийн сонгуулийн тойм(2013 он)
4. С.Жанцан (Sc.D), “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй” УБ., 2004
5. Саналын хуудсыг хэвлүүлэх хадгалах, хүргүүлэх хамгаалах журам. СЕХ-ны 2016 оны 17-р тогтоолын нэгдүгээр хавсралт
6. Хүний эрх, эрх чөлөө алдар хүнд, нэр төрийн эсрэг гэмт хэрэг. (сургалтын гарын авлага) УБ., 2007
7. “Иргэдийн улс төрийн болон бусад эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг” (сургалтын гарын авлага) УБ., 2013
8. Б.Хишигтогтох нар “Цахим мэдээллийн орчинд үйлдэгдэх гэмт хэргийг мөрдөн шинжлэхүйн онол, арга зүйн үндэс”, УБ., 2015
9. Сонгуулийн автоматжуулсан систем ач холбогдол.
http://www.interactive.mn/uploads/projects/brochure/brochure_1405928687.pdf

**Эрүүгийн хууль, Сонгуулийн тухай хуульд
заасан гэмт хэрэг, зөрчлийн ялгаа ба ижил төстэй тал**

Эрүүгийн хууль 130 дугаар зүйл. <i>Иргэн сонгуулийн эрхээ эдлэхэд болон сонгуулийн хорооны ажилд саад хийх</i>		Сонгуулийн тухай хууль
Эрүүгийн хуульд заасан үйлдэл эс үйлдэл	УДШ-ийн тайлбарт	
<p>Сонгох, сонгогдох болон бүх нийтийн санал асуулгад оролцох эрхэд “саад хийсэн”</p> <p>Хүснэгтээс харвал “саад хийсэн” үйлдэл нь сонгогч сонгуульд бие даан саналаа чөлөөтэй гаргах үйл ажиллагаа гэдэг нь мөн бөгөөд эрүүгийн эрх зүйн хувьд захиргааны зөрчлөөс ялгагдах шинжийг эрүүгийн эрх зүйн онолын үүднээс тайлбарлаж ойлгох нь зүйтэй.</p> <p>Гэмт хэргийн нийгэмд аюултай шинж байгаа эсэхэд анхаарна. Энэ гэмт хэргийн нийгэмд аюултай шинж нь саад хийсний улмаас иргэн, төр, нийгмийн эрх ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл тийм хор уршиг учрах бодит боломжийг бий болгосон байх явдал юм. Жишээлбэл сонгуулийн дүнд шууд нөлөөлсөн, сонгууль тойрог хэсгийн хороонд сонгууль явагдахгүй байх зэрэг хор уршигийг нь тодорхойлно.</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэн нь шууд буюу төлөөлөгчдийнбайгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй.</p> <p>Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ гэж заасан учраас төрийн удирдах эрхийг олгох сонгуулийн үйл ажиллагаанд сонгогчийн эрхийг эдлүүлэхгүй байгаа аливаа үйлдэл эс үйлдэл нь өөрөө саад хийсэн үйлдэлд тооцогдоно. Тухайлбал: -сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр саналаа нууцаар гаргах. -сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй. -сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө. -сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно. -сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.</p>	<p>4.4. Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.</p> <p>4.5. Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.</p> <p>4.7. Энэ хуулийн 4.4, 4.5-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл, эс үйлдэхүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнийг төрийн албанд хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр хална.</p>

¹⁵Улсын Дээд Шүүхийн 2009 оны 16-р тогтоол. Эрүүгийн хуулийн 18-р бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай.

<p>Сонгуулийн хорооны ажиллагаанд “саад хийсэн”</p>	<p>Сонгууль зохион байгуулах талаар эрх хэмжээнийхээ дотор гаргасан аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрийг холбогдох этгээд биелүүлэх үүргийг хуульчилсан бөгөөд сонгууль зохион явуулах байгууллагыг хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл үндэслэл бүхий шалтгаангүйгээр хүндрэл учруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно. Түүнчлэн үйл ажиллагааг хууль бусаар хязгаарлах, зогсоох, хяналт тогтоох, мэдээлэл олох боломжийг хаах, олсон мэдээллийг хууль бусаар хурааж авах, сонгуулийн ажилтныг албан тушаал бууруулах буюу ахиулах амлалт өгөх, мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох буюу хаах зэргээр илэрч болно.</p>	<p>Хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллагыг үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/ -г хэлнэ.¹⁶</p>	
<p>хүч хэрэглэж</p> <p>Ялгаа: Сонгуулийн хуульд зөвхөн ажиглагч, бие даагч нэр дэвшигчийн үйл ажиллагаатай холбоотой байна.</p>	<p>хүч хэрэглэсэн бол хүндрүүлж үзэхээр хуульчилсан.</p>	<p>УДШ-ийн 2007 оны 41-р тогтоолд 1.4 “Хүч хэрэглэх” гэж бие махбодийн хүчирхийлэл хийхэд чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдлийг хэлнэ.</p>	<p>107.11.Ажиглагч хуульд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал мэдээлэл нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж санал авах байрын ажилд хөндлөнгөөс оролцвол...</p> <p>129.1.6.бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа хүч хэрэглэх, 158.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо дараах тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзана: 158.1.4.бие даан нэр дэвшигч нь сонгогчдын</p>

¹⁶Улсын Дээд Шүүхийн 2009 оны 16-р тогтоол. Эрүүгийн хуулийн 18-р бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай.

			гарын үсгийг цуглуулахдаа дор дурдсан зөрчлийг гаргасан бол:158.1.4.б. хүч хэрэглэх;
хүч хэрэглэхээр заналхийлэх	Заналхийлэх нь гэмт үйлдлээ хийхийн тулд сэтгэл санааны болон биеийн хүчирхийлэл үзүүлэх болон бусдыг алах, гэмтэл учруулах, эд хөрөнгийг устгах, хууль ёсны эрх ашгийг зөрчих, нэр төрийг нь гутаах, хувийн нууцыг задруулна гэж сүрдүүлэх хэлбэртэй байж болно.	“Хүч хэрэглэхээр заналхийлэх” гэдэгт бусдыг айлган сүрдүүлэх зорилгоор хийсэн сэтгэл санааны хүчирхийллийг ойлгоно. Энэхүү хүчирхийлэл нь идэвхтэй үйлдлээр илрэх бөгөөд гэмт этгээд үүнийг үгээр илэрхийлэхээс гадна биет байдлаар үзүүлсэн байж болно.	29.1.6.бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа хуурч мэхлэх, заналхийлэх,
хуурч мэхлэх,	“...хуурч мэхлэх арга...” гэдэг нь бусдын эд хөрөнгө, түүнийг өмчлөх эрхийг өөртөө хууль бусаар олж авахын тулд үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэхийг хэлнэ. ¹⁷ Хуурч мэхлэх арга нь худал хэлэх, хуурамч баримт бичиг, факс, дүрс болон дуу авианы бичлэг, техник хэрэгсэл, компьютерийн мэдээлэл, сүлжээ ашиглах буюу тусгай албаны хувцас, хэрэглэл, цол, тэмдэг хэрэглэж зориудаар төөрөгдүүлэх, дутуу буюу зориулалтын бус, эсхүл хуурамч буюу чанарын доголдолтой эд зүйлээр төлбөр хийх зэргээр илэрнэ.	“хуурч мэхлэх” гэж Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т зааснаар буюу “үг болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох”-ыг хэлнэ. ¹⁸ гэж залилан мэхлэх гэмт хэргийн хуурч мэхлэх үйлдэлтэй адилтган үзсэн байна.	-3.1.9.“хуурч мэхлэх” гэж үг болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгохыг; -129.1.6.бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа “хуурч мэхлэх, сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус арга хэрэглэсэн, -158.1.4.бие даан нэр дэвшигч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа дор дурдсан зөрчлийг гаргасан бол:158.1.4.в. “хуурч мэхлэх; -158.1.3.нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;
эд мөнгөөр татах	Эд мөнгөөр татах объектив үйлдэл нь	УДШ-ийн 2008 оны 16-р тогтоолд	-3.1.10.“эд мөнгөөр татах” гэж мөнгө, эд

¹⁷Улсын Дээд Шүүхийн 2006 оны 51-р тогтоол. Эрүүгийн хуулийн 148-р зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх авах” гэмт хэргийг иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлын талаар.

¹⁸Улсын Дээд Шүүхийн 2009 оны 16-р тогтоол. Эрүүгийн хуулийн 18-р бүлгийн зарим зүйл заалтыг тайлбарлах тухай.

	<p>сонгуулийн үр дүнд нөлөөлөх эцсийн зорилготой шууд санаатай хэлбэртэй тэр санаа бодлоо хэрэгжүүлэхийн тулд мөнгө болон бусдад хэрэгтэй, хэрэг болохуйц зэрэг эд зүйл бараа материалаар хангах, амлах, өгөхөөр урьдчилан тохирох, бусдыг уриалан дуудсан мөнгө өгөх ажиллагааг зохион байгуулсан зэрэг зохион байгуулалтын шинжээрээ ялгагдана.</p>	<p>Мөн зүйлийн “эд мөнгөөр татах” гэдэгт мөнгө, эд хөрөнгө өгөх, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэргээр бусдын хүсэл зоригийн илэрхийлэлд нөлөөлөхийг ойлгоно.</p>	<p>хөрөнгө өгөх, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэргээр бусдын хүсэл зоригийн илэрхийлэлд нөлөөлөхийг;</p> <p>-129.1.6.бие даан нэрээ дэвшүүлэгч нь сонгогчдын гарын үсгийг цуглуулахдаа эд мөнгөөр татах;</p> <p>-140.2.2. нам нэр дэвшүүлэхдээ эд мөнгөөр татах үйл ажиллагаа явуулахыг хориглох;</p>
<p>санал худалдаж авах</p>	<p>Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх санаа зорилгоор хийгдэж байгаа ажиллагаа нь худалдан авсан буюу хариу төлбөр тооцоо хийгдснээр гэмт хэрэг төгс үйлдэгдэнэ.</p> <p>“Санал худалдаж авах” гэдэгт иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсхүл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгийн давуу эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн, эд мөнгөөр татах гэдэгт сонгогчид эд мөнгө өгөхөөр амласан зэргийг хамааруулна.</p>	<p>УДШ-ийн 2009 оны 16-р тогтоолд “санал худалдаж авах” гэдэгт иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсхүл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эсхүл эд хөрөнгийн давуу эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн, эд мөнгөөр татах гэдэгт сонгогчид эд мөнгө өгөхөөр амласан зэргийг хамааруулна.</p>	<p>3.1.11.“сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах” гэж мөнгө, эд хөрөнгө өгөх, амлах, дамжуулах, зуучлах, аливаа ажил, үйлчилгээг төлбөргүй үзүүлэх зэрэг бүх төрлийн арга, хэлбэрээр сонгогчийнсанал өгөх эрхийг өөрийн сонирхолд нийцүүлж, тодорхой нам, эвсэл, нэр дэвшигчид санал өгүүлэх зорилгоор явуулж байгаа ажиллагааг;</p> <p>70.5.3.сонгогчдын саналагы татах зорилгоор энэ хуульд зөвшөөрснөөс бусад бүх төрлийн үйлчилгээ зохион байгуулах, ивээн тэтгэх;</p> <p>70.5.10.сонгогчдын саналыг татах зорилгоор өөрөө болон бусдаар дамжуулан, эсхүл хүмүүнлэгийн, буяны, шашны байгууллага болон төрийн бус байгууллага, сангийн нэрээр халхавчлан сонгогч, түүний гэр бүлийн гишүүн, насанд хүрээгүй хүн, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй</p>

			тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах, цалин хөлс, урамшуулал, тэтгэлэг олгох; 70.5.14.сонгогчийн санал татах зорилгоор сонгогчид эдийн болон эдийн бус давуу байдал олгох, олгохоор амлах; 70.5.16.сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах;
130' дүгээр зүйл. Сонгууль болон ард нийтийн санал асуулгад хууль бусаар илүү санал өгөх			
санал хураалтын дүнд хууль бусаар нөлөөлөх, будлиантуулах зорилгоор саналын хуудас ашиглан нэгээс илүү удаа санал өгсөн, эсхүл нэгээс илүү удаа санал өгөхийг санаатайгаар зохион байгуулсан болбусаар нөлөөлөх,	Санал хураалтын дүнд нөлөөлж байгаа хууль бус үйлдэл нь нэгээс илүү удаа санал өгөх, эсвэл уг үйлдлийг санаатайгаар зохион байгуулсан идвэхтэй үйлдэл байна. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулиар сонгогчийн санал өгөх ажиллагаа нь биеийн давхцахгүй өгөгдөлөөр өгч байгаа тул саналыг нэгээс илүү өгөх боломжгүй юм. Хэрэв нэгээс илүү өгсөн бол энэ нь сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулан явуулж байгаа субъектүүдтэй холбоотой болно. Иймд санаа зорилго нь зохион байгуулалтын шинжийг анхаарна.		3.1.16.“сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн” гэж сонгогч саналаа чөлөөтэй өгөх эрхэд хөндлөнгөөс хууль бус аливаа хэлбэрээр нөлөөлсний үр дүнд түүний саналыг хүсэл зоригийн жинхэнэ илэрхийлэл, түүнчлэн санал хураалтын эцсийн дүнг бодит байдалд нийцсэн дүнг гэж тус тус үзэх боломжгүй болохыг;
131 дүгээр зүйл. Сонгуулийн болон бүх нийтийн санал хураалтын баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах			
зохион байгуулах хорооны дарга, гишүүн, <u>бусад албан тушаалтан</u> сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн,	Хуурамчаар үйлдэх үйлдэл нь сонгуулийг зохион байгуулж байгаа албан тушаалтан нартай шууд холбогдоно. “бусад албан тушаалтан” гэдэгт нэр дэвшигчдийн болон сонгогчдын нэрсийн жагсаалт, нэр дэвшигчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэрэг сонгуулийн баримт бичгийг олгох үндэслэл		3.1.8.“гарын үсэг хуурамчаар үйлдэх” гэж бүх төрлийн арга хэрэглэн /өөрөө, эсхүл өөр этгээдээр үйлдүүлэх, техник хэрэгсэл ашиглах гэх мэт/ бусдын гарын үсгийг дуурайлгаж буюу хуулбарлаж, эсхүл зохиож зурах, сонгуулийн эрхгүй хүмүүсээр гарын үсэг

	болж буй анхан шатны бүртгэл, баримт бичиг, иргэний үнэмлэхийг энэ зүйл, заалтад дурьдсан зорилгоор хуурамчаар үйлдсэн албан тушаалтныг хамааруулж ойлгоно.		зуруулахыг; 29.5.Сонгуулийн байгууллагын ажилтан, албан тушаалтан дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 29.5.7.гарын үсэг хуурамчаар үйлдэх;
Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3-т заасныг ноцтой зөрчиж санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан,			
57.4-т заасныг ноцтой зөрчиж буруу шийдвэрлэсэн,			
сонгогчоос санал нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн,	Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар тогтоосон саналаа чөлөөтэй илэрхийлэх журмыг зөрчсөн, сонгуулийн хэсэгт саналаа тэмдэглэх, тасалгаа, хаалтгүй байх, саналаа тэмдэглэхэд нь элдэв саад үүсгэх, тухайн сонгогчоос өөр гадны хүнийг дэргэд нь байлгах, саналаа хэрхэн өгч байгаа байдалд нь шууд хяналт тавих, саналын хайрцгийг бүтүүмжлэхгүй байх, саналын хуудсанд тэмдэглэл хийж чадахгүй сонгогчийн саналыг итгэмжлэгдээгүй хүнээр тэмдэглүүлэх, тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, тэмдэггүй саналын хуудсаар санал өгүүлэх зэрэг хэлбэрээр илэрч болно.	“ИТГЭМЖИЛСЭН ХҮН” гэж сонгогчийн өөрийн хүсэл зоригийн дагуу тухайлан сонгож, санал авах байранд дагуулж ирсэн, санал өгөхөд нь унших, бичих хэлбэрээр туслалцаа үзүүлэх чадвартай, насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг хэлнэ. Сонгогчийн итгэмжилсэн хүний эрх зүйн байдлыг түүний иргэний үнэмлэхээр тодорхойлно.	4.5.Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.